



Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ДААТГУУЛАГЧДЫН ХӨРӨНГӨНД ҮРЭЛГЭН ХАНДСАН БАЙНА



УАГ-2/2006/01-ГА

НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт,
НД-ын байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт

Улаанбаатар
2006 оны 3 дугаар сар



**Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны
хүсэлтээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

**ДААТГУУЛАГЧДЫН ХӨРӨНГӨНД
ҮРЭЛГЭН ХАНДСАН БАЙНА**

**НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт,
НД-ын байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалт**

YAG-2/2006/01-ГА

**Улаанбаатар
2006 оны 3 дугаар сар**



Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын хоёрдугаар хэлтэс

Тэргүүлэх аудитор: О.Мэндбаяр
Ахлах аудитор: М.Давааням
Аудитор: З.Цээнээ
Шинжээч: Б.Сугармаа
Ц.Наранцэцэг
Л.Эрдэнэчулуун

2006 оны 3 дугаар сар
Улаанбаатар хот

Уг тайланг ҮАГ-ын вебсайтаас үзнэ үү:
www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ: Үндэсний аудитын газар,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46,
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт:

- УИХ - Улсын Их хурал
- НББХ - Нийгмийн бодлогын байнгын хороо
- ҮАГ - Үндэсний аудитын газар
- ЗГ - Засгийн газар
- ЗГХА - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
- СЭЗЯ - Санхүү, эдийн засгийн яам
- СЯ - Сангийн яам
- НХХЯ - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
- НДҮЗ - Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
- УНДЕГ - Нийгмийн даатгалын ерөнхий газар
- НДХ - Нийгмийн даатгалын хэлтэс
- НДС - Нийгмийн даатгалын сан
- НДШ - Нийгмийн даатгалын шимтгэл
- ЭМДС - Эрүүл мэндийн даатгалын сан
- ТБУСТХ - Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- ТБОНӨХХА
- БАҮГСЖТХ- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хууль
- ХХК - Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- ХК - Хувьцаат компани

ГАРЧИГ

1. ТАНИЛЦУУЛГА:

НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт.....	4
НД-ын тогтолцоо.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4
Аудитад ашигласан шалгуур, стандартын мэдэгдэл.....	5

2. АУДИТЫН ТАЙЛАН:

НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт.....	6
НДС-гийн орлого бүрдүүлэлт.....	6
НДС-гийн зарцуулалт.....	8
НДС-гийн хуримтлагдсан үр дүн.....	8
НДШ-ийн авлага барагдуулалт, хураагдсан барааны хадгалалт, хамгаалалт, борлуулалт.....	9

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын санхүүжилт, зарцуулалт.....	12
Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хянах, батлах.....	12
Олгогдсон санхүүжилтийг захиран зарцуулж байгаа байдал.....	13
Худалдан авалтад тендер Шалгаруулсан байдал.....	14
Өөрийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт.....	18

Удирдлагын үйл ажиллагаа.....	19
Орон тоо, бүтэц, боловсон хүчний сонгон шалгаруулалт.....	19
Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэж буй байдал.....	20
Үндсэн чиглэлийн зорилтыг хангуулахаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.....	21

Дотоод хяналтын тогтолцоо.....	22
Дотоод хяналтын тогтолцоо, чиг үүрэг.....	22

Тэтгэвэр, тэтгэмж олголт.....	23
Тэтгэвэр тэтгэмж олголт, өрийн үлдэгдэл барагдуулалт.....	23

НДҮЗ-ийн үйл ажиллагаа.....	24
------------------------------------	-----------

2. САНАЛ

НХХ-ийн сайдын санал.....	26
УНДЕГ-ын санал.....	28

3. САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

НХХ-ийн сайдын саналд өгсөн тайлбар.....	29
УНДЕГ-ын саналд өгсөн тайлбар.....	30

4. АЛБАН ШААРДЛАГА

УНДЕГ-ын дарга С.Эрдэнэд.....	32
-------------------------------	----

5. АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны дарга Ч.Улаанд.....	33
УИХ-ын НББХ-ны дарга Т.Гандид...33	33
Сангийн сайд Н.Баяртсайханд.....	33
НХХ-ийн сайд Л.Одончимэдэд.....	33
НДҮЗ-ийн дарга С.Чинзоригт.....	34
УНДЕГ-ын дарга С.Эрдэнэд.....	34

6. ХАВСРАЛТУУД

Хавсралт №1	36
Хавсралт №2	37
Хавсралт №3	38
Хавсралт №4	39
Хавсралт №5	40



Танилцуулга

НД-ын тогтолцоо

Монгол Улсын НД-ын тогтолцоо нь ажил олгогч ба даатгуулагчдын төлсөн шимтгэлийн орлогыг тодорхой санд төвлөрүүлж, тодорхой шалгуур (шимтгэл төлж ажилласан жил, нас г.м) хангасан иргэдэд тэтгэвэр, тэтгэмж олгох зориулалттай билээ.

НДС нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй:

- Тэтгэврийн даатгалын сан
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан
- Ажилгүйдлийн даатгалын сан
- Тэтгэмжийн даатгалын сан
- Эрүүл мэндийн даатгалын сан

УНДЕГ нь НХХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах ЗГХА статустай байгууллага бөгөөд, НД-ын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, НДС-г бүрдүүлж, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах, НДС-гаас тэтгэвэр тэтгэмжийг цаг тухайд нь олгох үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байна. УНДЕГ-ын харьяанд Нийслэлийн НД-ын газар болон аймаг, дүүргийн 30 НДХ ажиллаж байна. *(Хавсралт №1-ийг үзнэ үү)*

НДҮЗ нь орон тооны бус гишүүнчлэлтэй, нийгмийн даатгалын харилцаанд даатгуулагч, ажил олгогч, ЗГ-ын тэгш оролцоог хангаж, НДС-гийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих, НД-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллага юм.

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос ирүүлсэн хүсэлтээр УНДЕГ-ын 2005 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлийн аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудит нь дараах зорилтын хүрээнд шалгалт хийж, дүгнэлт гарган, зөвлөмж өгөхөд чиглэгдсэн. Үүнд:

- НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт;
- НД-ын байгууллагын хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны санхүүжилт, түүний зарцуулалт;
- Удирдлагын үйл ажиллагаа;
- Дотоод хяналтын тогтолцоо, түүний үр нөлөө;
- Тэтгэвэр, тэтгэмж олголт, өрийн үлдэгдэл, барагдуулалт;
- НДҮЗ-ийн үйл ажиллагаа, үр нөлөө.

Энэ удаагийн гүйцэтгэлийн аудитад НДШ ногдуулалт болон тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл, тооцоог хамруулаагүй болно.

Танилцуулга

үргэлжлэл

НДҮЗ болон УНДЕГ, аймаг, дүүргийн НДХ-үүдийн НДС-гийн тайлан, НД-ын байгууллагуудын санхүүгийн тайлангууд болон тэдгээрийн нэгтгэлүүдийг холбогдох анхан шатны баримт, гэрээ хэлцэл, хурлын шийдвэр, тогтоол, тушаал, батлагдсан журам, заавар, ажлын байрны тодорхойлолтууд, хөдөлмөрийн гэрээ зэрэг баримт бичгийг уншиж танилцан, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, тайлбар, мэдээ гаргуулах байдлаар аудитын шинжилгээний болон нарийвчилсан горимын дагуу сорил, дүн шинжилгээ хийв.

Аудитад ашигласан шалгуур, стандартын мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн акт, баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгов.

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль;
- Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл;
- НДҮЗ-ийн дүрэм;
- Холбогдох бусад хууль, эрхийн актууд.

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Монгол Улсын Ерөнхий аудитын баталсан ҮАГ/2/2006/01-ГА гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгов.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүгнэлтийг нотлох зүйлс, тэдгээрийг дэмжих болон холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материал болгон хавсаргав.

Гүйцэтгэлийн аудитыг ҮАГ-ын тэргүүлэх аудитор О.Мэндбаяр хянан удирдаж, УНДЕГ-т ҮАГ-ын, орон нутгийн НДХ-үүдэд аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээчид 2006 оны 1 дүгээр сарын 5-аас 3 дугаар сарын 3-нд хийж гүйцэтгэлээ.

НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт

1. НДС-гийн орлого бүрдүүлэлт

2005 онд НДС-гийн орлогын төлөвлөгөө 5%-иар буюу 8,9 тэрбум төгрөгөөр давж биелснээр оны эцэст НДС-д хуримтлагдсан хөрөнгө буюу зарцуулагдаагүй үлдэгдэл 125 тэрбум төгрөгт хүрчээ.

2005 оны гүйцэтгэлээр тооцож үзвэл энэ нь НДС-гаас олгох тэтгэвэр тэтгэмжийн 10 сарын нөөц юм.

Иймд НДС-гийн буюу даатгуулагчдын хөрөнгийг эрсдэлд оруулахгүйгээр, санхүүгийн менежментийг оновчтой хийж чадвал НДС-д багагүй хэмжээний орлого нэмж олох боломжтой болох төдийгүй цаашдаа сан бүрэн биеэ даах, улмаар НДШ-ийн өнөөгийн мөрдөгдөж байгаа хувь хэмжээг ч бууруулах боломж харагдаж байна.

НДС-гийн 2005 оны орлогын төлөвлөгөөний биелэлт:


НДС-гийн төрөл	2004 оны гүйцэтгэл	2005 оны		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн сан	113099,4	120106,7	125100,7	4%
Тэтгэмжийн сан	7064,9	7370,8	8345,7	13%
ЭМД-ын сан	28468,3	30879,7	32574,2	5%
ҮОМШӨД-ын сан	5176,3	5223,8	6067,1	16%
АД-ын сан	3529,9	3803,4	4262,3	12%
Бүгд дүн	157338,8	167384,4	176349,9	5%

НДШ хэрхэн төлөгдөж байгаа талаархи нэгдсэн мэдээлэл алга байна

УНДЕГ НДШ-ийн ногдуулалтын мэдээг нэгтгэн гаргаж байгаа боловч цаг хугацаанд нь төвлөрүүлж байгаа эсэхийг хянаж, мэдээлж ирээгүйгээс НДС-г цаг хугацаанд нь бүрэн бүрдүүлж байгаа эсэх талаар дүгнэх боломжгүй байна. Иймд НДҮЗ НДС-гийн орлогыг хянаж, батлахдаа НДШ ногдуулалт болон түүнийг хэдийд, хэрхэн барагдуулахыг тусгайлан тодорхойлж, биелэлтийг хангуулж байх шаардлагатай байна.

НДШ-ийн орлогын 74,17% нь даатгуулагчид, тэдгээрийн ажил олгогч аж, ахуйн нэгж байгууллагуудаас төлөгдөж байгаа бол 25,06% нь төрөөс хариуцах иргэдийн ЭМД-ын хураамж, тэтгэвэр, төсвийн байгууллагаас ажиллагсдын өмнөөс төлсөн төлбөрөөс бүрдэж байна.

НДС-гийн бусад орлогод сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд байршуулснаас олсон хүүгийн орлого голлох хувийг эзэлж байна. Төрийн сангийн газар гэрээний үүргээ биелүүлээгүйгээс 2005 онд хүүгийн орлого олох боломж 789,9 сая төгрөгөөр алдагджээ.



НДС-гийн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулж, холбогдох хууль тогтоомжийг зөрчжээ

УНДЕГ 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Зоос, ХААН, Улаанбаатар, Монгол шуудан зэрэг арилжааны банкуудад 5,2 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж байдлаар байршуулсан нь НДТХ-ийн 2 дугаар бүлгийн 11.2-т “Сангийн хөрөнгийг зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно”, “Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх журам”-ын 2.8-т “НД-ын байгууллага нь СЭЗ-ийн сайдын тусгай зөвшөөрөлгүйгээр төрийн сангаас гадуур банк болон санхүүгийн байгууллагад данс нээхийг хориглоно” гэж заасныг зөрчиж байна.

Төрийн сангийн газар гэрээний үүргээ биелүүлээгүй байна

СЭЗ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2003 оны 45/21 дүгээр тушаалаар батлагдсан “НДС, НДС-ын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх журам”-ын дагуу УНДЕГ болон Төрийн сангийн газрын хооронд 2005 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан 2005/01 дугаартай гэрээний биелэлтийг шалгахад Төрийн сангийн газар НДС-д 789,9 сая төгрөгийн хүүг төлөөгүй байна.

Дүгнэлт

НДС-гийн хөрөнгийг Төрийн санд төвлөрүүлэн байршуулж байгаа нь даатгуулагчдын хөрөнгийг эрсдэлээс хамгаалах давуу талтай боловч Төрийн сангийн газар гэрээний үүргээ биелүүлээгүй, хүүгийн төлбөрийг зохих ёсоор төлөөгүй, арилжааны банкуудын түвшингээс доогуур хүү тогтоож байгаагаас НДС-ын байгууллагууд холбогдох хууль тогтоомжийг зөрчин, НДС-гийн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулах болсон байна.

Иймд НДС-гийн хөрөнгийг эрсдэлд өртүүлэхгүйгээр өсгөн арвижуулах боломжийг судлах, тухайлбал НДС-гийн зарцуулагдаагүй үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Монгол банкинд хадгаламж хэлбэрээр байршуулан, хүү тооцуулан авах асуудлыг судлан, зохих ёсоор шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Улсын төсвөөс НДС-д олговол зохих хөрөнгө бүрэн олгогдохгүй байна.

НДТХ-д 1995 оноос өмнө тэтгэврийн эрх үүссэн иргэдийн тэтгэвэрт зарцуулах хөрөнгийг жил бүрийн Улсын төсөвт суулгах замаар төр хариуцаж байхаар заажээ. Гэвч Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд олгох хөрөнгийг тодорхойлохдоо зөвхөн тухайн сангийн орлогоос давсан зарлагын дүнг санхүүжүүлэх зарчим баримталж иржээ. 1995 оноос өмнө тэтгэвэрт гарагчдад олгосон тэтгэвэрт Улсын төсвөөс олгогдоогүй санхүүжилтийн дутууг НДС-гаас нөхөн санхүүжүүлж ирсэн нь 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 152,2 тэрбум төгрөг болжээ. Үүнээс шалтгаалан Тэтгэврийн даатгалын санд хангалттай

хуримтлал төвлөрч чадахгүй байна. Өнгөрсөн онтой харьцуулахад НДС-ын бусад төрлийн сангийн хуримтлал 22,6-34,6% өссөн байхад Тэтгэврийн даатгалын сангийн хуримтлал 0,4%-иар буурсан байна.

Гэтэл Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу 1960 оноос хойш төрсөн даатгуулагчид тус бүр дээр нээгдсэн тэтгэврийн даатгалын нэрийн дансны тооцоологдсон үлдэгдэл 2005 оны эцэст 330 гаруй тэрбум төгрөг болоод байгаа билээ.

Энэ нь “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”-д тодорхойлсон орлогоороо зарлагаа нөхөх хуваарилалтын уламжлалт тогтолцоог халж, “...2005 оноос тэтгэврийн нэрийн дансны хагас хуримтлалын тогтолцоонд шилжих угтвар нөхцөлийг бүрдүүлж эхлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу НДҮЗ төрөөс ЭМД-ыг хариуцах иргэдийн даатгалын хураамжийн хэмжээг сар тутам 500 төгрөгөөр тогтоосон боловч 2005 оны нэгдсэн төсөвт энэ нь 300 төгрөгөөр тооцогдон батлагдаж, санхүүжигдсэн байх бөгөөд зөрүүг тооцож үзвэл 1,6 тэрбум төгрөг болж байна.

ЭМДС-гийн хуримтлагдсан үлдэгдэл 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 30,3 тэрбум төгрөгт хүрээд байгаа нь бусад сантай харьцуулахад харьцангуй их болж, өнгөрсөн жилийн гүйцэтгэлээр тооцоход 1,2 жилийн нөөц бүрдээд байгааг харгалзан төрөөс ЭМД-ын төлбөрийг хариуцах иргэдийн даатгалын хураамжийн хэмжээг 500 болгож нэмэгдүүлсэн шийдвэрийг эргэж харах нь зүйтэй байна.

2. НДС-гийн зарцуулалт

2005 онд НДС-гаас тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 345.4 мянгаас 380.0 мянга болж, ЭМДС-гаас төлбөр авдаг үйлчлүүлэгчид давхардсан тоогоор 4272.5 мянгаас 4725.4 мянга болж өссөнөөс үзэхэд НДС-гийн зарлага жилээс жилд нэмэгдэх үндсэн шалтгаан нь НДС-гаас төлбөр авагчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Монгол Улсын 2005 оны төсвийн тухай хууль болон НДҮЗ-ийн 2005 оны 1 дүгээр тогтоолоор НДС-гийн зарлага 157142,1 сая төгрөгөөр батлагдсан боловч НДҮЗ 2005 онд нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 6 удаа тодотгол хийж, анхны батлагдсан хэмжээг 1762,4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, УНДЕГ-ын даргын “Нийгмийн даатгалын зарим сангийн зарлагын 2005 оны төсвийн тодотголыг батлах тухай” 361 дүгээр тушаалаар тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлагыг 3167,4 сая төгрөгөөр нэмэх шийдвэр гарснаар НДС-гийн зарлагын төлөвлөгөө 163390,1 сая төгрөг болжээ.

НДС-гийн зарлага

	2004 он	2005 он	Зөрүү	
			үнэ	%
Тэтгэвэр, тэтгэмж	116233.6	132164.9	15931.3	14%
ЭМД-ын төлбөр	20901.5	23689.2	2787.7	13%
НД-ын зардал	3952.3	6683.4	2731.1	69%
Алдангийн 20%	186.9	192.7	5.8	3%
Бусад	430.4	102.3	-328.1	-76%
Нийт зарлага	141704.8	162832.5	21127,7	15%

3. НДС-гийн хуримтлагдсан үр дүн

2005 онд НДС-гийн хуримтлагдсан үр дүн буюу “зарцуулагдаагүй үлдэгдэл” Тэтгэврээс бусад төрлийн даатгалын сангуудад өсчээ.

НДС-гийн зарцуулагдаагүй үлдэгдэл

Зарцуулагдаагүй үлдэгдэл сан тус бүрээр	2004	2005	Зөрүү	
			Дүн	хувь
Тэтгэврийн даатгалын сан	73'045,6	72'765,2	-280,4	-0,4%
Тэтгэмжийн даатгалын сан	8'973,9	11'876,6	2902,7	32,3%
Эрүүл мэндийн даатгалын сан	26'995,0	34'154,7	7'159,7	26,5%
УОМШӨ-ний даатгалын сан	5'226,9	6'409,9	1'183,0	22,6%
Ажилгүйдлийн даатгалын сан	7'931,2	10'697,9	2'748,7	34,6%
Бүгд дүн	122'172,6	135'904,3	13'731,7	11,2%

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг нэвтрүүлэх шаардлагатай байна

2005 оны НДС-гийн санхүүгийн тайлангаас үзэхэд дампуурсан банкуудаас авах авлага 10,9 тэрбум, НДШ-ийн болон банкны өрийн төлбөрт хурааж авсан бараа, объект 1,9 тэрбум төгрөг байгаа нь нийлбэр дүнгээрээ дээрх зарцуулагдаагүй үлдэгдлийн 10,5% болж байна.

Эдгээр нь бүртгэгдсэн дүнгээрээ НДС-д мөнгөн орлого болж төлөгдөх магадлал багатай бөгөөд тэр тусмаа дампуурсан банкуудаас авах авлага нь УНДЕГ-ын хяналтад байгаа хөрөнгө биш.

Тиймээс Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт №37-д нийцүүлэн энэхүү 10,9 тэрбум төгрөгийн авлагыг хөрөнгийн дүнгээс хасаж, НДС-гийн зарцуулагдаагүй үлдэгдлийг бууруулж тайлагнах нь зүйтэй юм.

Энэ нь холбогдох авлагыг данс бүртгэлээс хасаж биш, харин нягтлан бодох бүртгэл, тооцоог заавал хөтөлж, барагдсан хэмжээгээр буюу бодитой хөрөнгө болж, өөрийн хяналтад авсан тохиолдолд санхүүгийн тайланд хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрч, тайлагнах асуудал юм.

НДС-гийн санхүүгийн тайлан, мэдээ цаг хугацаандаа гарч хэвшжээ

УНДЕГ НДТХ-иар хүлээсэн үүргийн дагуу тайлан тэнцлийг улирал, жилээр нэгтгэн гаргаж хэвшжээ.

2005 оны НДС-гийн орлого, зарлагын тайланг аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага 1 дүгээр сарын 25-ны дотор, УНДЕГ 2 дугаар сарын 18-нд нэгтгэн гаргасан.

Ингэхдээ НДС-гийн орлого, зарлагын удирдлагыг шуурхай, боловсронгуй болгоход шаардагдах мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор холбогдох судалгааг аль болох дэлгэрэнгүй байдлаар гаргуулж, нэгтгэж байх шаардлагатай байна.

4. НДШ-ийн авлага барагдуулалт, хураагдсан бараа, объектын хадгалалт, хамгаалалт, борлуулалт

2005 онд НДШ-ийн авлага өмнөх оноос 369,5 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч НДС-гийн бүрдүүлэлтэд эзлэх хувийн жин өмнөх оноос 0,7%-иар буурчээ.

НДШ-ийн авлага, түүний барагдуулалтын мэдээ

Үзүүлэлт	2004	2005	(сая төгрөгөөр)	
			Зөрүү дүн	хувь
Нийт авлага	8313800	8683300	369.5	4%
Авлага барагдуулалт	109499.5	132145.5	22646	21%
Үүнээс:				
- мөнгөөр	108998.5	131035.2	22036.7	20%
- бараагаар	322.4	859.4	537	167%
- хүчингүй болгосон	178.7	250.9	72.2	40%

2005 оны байдлаар авлагын нийт үлдэгдлийн 3408,4 сая төгрөг буюу 39,2% нь шүүхийн шийдвэртэй байна.

НДҮЗ-ийн 2005 оны 29 дүгээр тогтоолоор 81 ажил олгогчтой холбоотой 241,3 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг хүчингүй болгож, данс бүртгэлээс хасахдаа татан буугдсан талаархи сонины зар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанаас ирүүлсэн шийдвэр гүйцэтгэлийн

ажиллагааг түдгэлзүүлсэн албан бичиг, Татварын албаны татан буулгасан тухай шийдвэр зэргийг үндэслэл болгожээ. Энэ нь НДШ-ийн өр төлбөрийн үүргээс чөлөөлөх хангалттай шалтгаан болж чадахгүй байна.

НДШ-ийн төлбөрийн үүргээс чөлөөлөх хууль эрх зүйн зохицуулалтгүй байгааг далимдуулан НДҮЗ болон УНДЕГ НДШ-тэй холбоотой авлагыг хүчингүй болгож, данс бүртгэлээс хасахыг урьтал болгох биш, харин өр авлага үүсгэхгүй байх, үүссэн тохиолдолд бүрэн барагдуулах талаар ажиллах шаардлагатай байна.

Хураагдсан барааны хадгалалт хамгаалалт хангалтгүй байна

Эд хариуцагч С.Туяагийн хариуцаж буй шимтгэлийн өрөнд хураагдсан барааны үлдэгдлийг түүвэрлэн шалгаж үзэхэд 1997-2001 онд хураагдсан монгол дарс, лаазалсан мөөг зэргийг худалдан борлуулаагүйн дээр хадгалалтын нөхцөлийг хангаагүйгээс болон хугацаа дууссанаас хэрэглээний шаардлага хангахааргүй болжээ. Мөн шимтгэлийн өрөнд авсан гэх 30 ширхэг сейфийг гадаа ил хадгалж байгаагаас зэвэрч, өнгө үзэмж нь мууджээ.



Гадаа хураалттай байгаа сейф

УНДЕГ-т дотоод хяналт хариуцсан нэгж байгаа боловч дотоод хяналт, шалгалтын ажлын тайлангаас үзэхэд хураагдсан барааны үнэлгээ, хадгалалт хамгаалалтын байдлыг огт шалгаж, дүгнэж байгаагүй, энэ талаар чиг үүрэгт нь тодорхой тусгаагүй байна.

НДС-гийн бүрдүүлэлт,
зарцуулалт

үргэлжлэл



Агуулахын дотор эд барааг төрөлжүүлэн ангилалгүй, эмх цэгцгүй овоолсон байна.

Хурааж авсан барааны үлдэгдэл 2005 оны эцэст 1948,9 сая төгрөг байгаагийн 49,9% нь 972.7 сая төгрөгийн 6 ширхэг барилга объект, 1,5% нь 30.5 сая төгрөгийн цахилгаан бараа, 945.8 сая төгрөгийн бусад бараа байна.

НДШ-ийн өрөнд бараа хурааж авах явдал өмнөх оноос 73%-иар, бараа борлуулалт 9,3%-иар тус тус буурчээ.

Хураагдсан барааны үлдэгдэл,
борлуулалтын мэдээ

Үзүүлэлтүүд	2004 он	2005 он	(сая төгрөгөөр)	
			Зөрүү	
			Дүн	хувь
НДШ-ийн өрөнд авсан бараа, объект	1247,8	1212,3	-35,5	-3%
Банкны өрөнд авсан бараа, объект	3777,1	736,6	-3040,5	-80%
Бүгд дүн	5024,9	1948,9	-3076,0	-61%
Үүнээс:				
Тайланг онд - нэмэгдсэн	3224,2	859,4	-2364,8	-73%
- борлуулсан	237,2	227,9	-9,3	-4%
- үнэ бууруулсан		42,7	42,7	

НДШ-ийн төлбөрт бараа, объектыг өндөр үнээр үнэлж авч байснаас НДС-д их хэмжээний алдагдал учраад байна

1997-2001 онд НДШ-ийн өрөнд хурааж авсан бүгд 1421,7 сая төгрөгийн 13 объект болон бусад бараа бүтээгдэхүүнийг 2005 онд эрх бүхий мэргэжлийн байгууллагаас хийсэн дахин үнэлгээгээр болон НДҮЗ-ийн шийдвэрээр 858,7 сая төгрөг болгож үнэлгээг 51,9%-иар бууруул-

наар НДС-д 683,6 сая төгрөгийн алдагдал учирчээ.

НДШ-ийн өрөнд бараа, объектийг үнэлж авч байгаа явдлыг дараахь үндэслэлээр цаашид бүрэн таслан зогсоох нь зүйтэй гэж үзэж байна.

Үүнд:

- НДС-ын байгууллагууд НДШ-ийн өрөнд бараа объект хураан авах нь хууль тогтоомжоор зохицуулагдаагүй;
- Хураан авч байгаа бараа, объектыг өндөр үнээр үнэлж, НДШ-ийн тооцоог бууруулж, хааж байгаа дүн нь тэдгээрийг худалдан борлуулснаас НДС-д төвлөрч байгаа мөнгөн орлогын дүнгээс зөрүүтэй бөгөөд НДС-д ихээхэн хэмжээний алдагдал учруулах болсон.

Нийтийн дуудлага худалдаа зохион байгуулалгүй бараа объектыг худалджээ

НДҮЗ-ийн 2005 оны “Бараа бүтээгдэхүүний борлуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолоор барилга, байгууламжийг худалдан борлуулахдаа нийтийн дуудлага худалдаа зохион байгуулах болон санхүүгийн лизенгээр худалдах шийдвэр гаргажээ.

УНДЕГ 5 объектын нийтийн дуудлага худалдааны зарыг “Зууны мэдээ” сонинд зарлуулахдаа ТӨХ-ноос баталсан “Дуудлага худалдааны нийтлэг журам”-ыг зөрчиж, 14 хоногийн хугацаатай гаргасан байх бөгөөд худалдах объектын талаар тодорхой мэдээлээгүй төдийгүй дуудлага худалдааны доод үнийг ч зарлаагүй байна.

Богд Хан уулын Залаатын аманд байрлах 314,1 сая төгрөгийн үнэтэй байсан “Залаат” амралтын үнийг дахин үнэлгээгээр 59.3 сая төгрөгөөр бууруулжээ. Энэ нь тус объектын зөвхөн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ буюу зардлын хандлагын аргаар өртөгт үндэслэн тогтоосон үнэ бөгөөд эргэлтийн хөрөнгө болон зах зээлийн үнэ цэнийн бусад нөлөөллийг агуулаагүй байна. Үүний дараа НДҮЗ-ийн шийдвэрээр дээрх үнийг 10% -иар бууруулж, дуудлагаар худалдах доод үнийг 230,0 сая төгрөг болгожээ.

НДС-гийн бүрдүүлэлт,
зарцуулалт

үргэлжлэл

Үнэ бууруулсны дараа энэ объектыг худалдах зарлалыг дахин гаргаагүй бөгөөд “Монголын алтан аялал” ХХК-тай шууд худалдах, худалдан авах гэрээ хийж, 2006 оны 1 дүгээр сарын 18-нд худалдсан байна.



Богд Хан уулын Залаатын аманд байрлах
“Залаат” амралт

“Залаат” амралтыг хүлээлгэн өгөхдөө 51,0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг төлбөр тооцоонд огт тусгаагүй боловч тус амралтын газрын хуримтлагдсан өр төлбөр 13,1 сая төгрөгийг УНДЕГ-т хариуцуулсан байна.

Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах нэрээр НДС-гийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна

УНДЕГ НДШ-ийн өрөнд хураагдсан хөрөнгийг борлуулах, өр барагдуулах талаар “Марагал” ХХК-тай хамтран ажиллах гэрээ 2005 оны 7 дугаар сард байгуулжээ. Гэрээнд тус компани 11 аж, ахуйн нэгжтэй холбогдох 610,0 сая төгрөгийн НДШ-ийн өрийг барагдуулж, үнийн дүнгийн 20%-ийг урамшуулалд авахаар заажээ.

“Марагал” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй атал “Шарын гол” ХК-ний НДШ-ийн өрөнд хураагдсан хөрөнгийг төв, орон нутгийн НД-ын байгууллагуудад УНДЕГ-ын шийдвэрээр хуваарилан олгуулсан үйл ажиллагаандаа 18,8 сая төгрөгийн урамшуулал авчээ. Хураагдсан барааны үнэ зах зээлийн үнээс ихээхэн өндөр болохыг холбогдох НДХ-дэд хийсэн аудитын тайланд дурджээ. Тухайлбал, 17 инчийн хэмжээтэй компьютерийн дэлгэц 83 ширхэгийг нэг бүрийг нь 1020,0 мянган төгрөгөөр үнэлж авсан байна.

Тус компани Нийгмийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3-т “Нийгмийн даатгалын байцаагчаас тавьсан актад заасан шимтгэл, алданги, хүү торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол уг шимтгэл, алданги, хүү торгуультай тэнцэх хэмжээний хөрөнгийг гаргуулах”, 26 дугаар зүйлийн 2.4-т “тогтоосон хугацаанд төлөөгүй шимтгэл болон нөхөн ногдуулсан шимтгэл, алданги, хүү торгуулийг шимтгэл төлөгчөөс үл маргах журмаар гаргуулах” гэж заасныг хэрэгжүүлэх (энэ компани ийм эрхгүй) зорилгоор Дарханы Төмөрлөгийн үйлдвэртэй “НДШ-ийн хуримтлагдсан өр барагдуулах гэрээ” байгуулжээ.

Дархан-Уул аймгийн аудитын газраас тус аймгийн НДХ-т хийсэн аудитын тайлангаас үзэхэд Дарханы Төмөрлөгийн үйлдвэр НДШ-ийн хуримтлагдсан өр төлбөргүй байжээ.

Байгуулсан гэрээний нөхцөл ёсоор Дарханы Төмөрлөгийн үйлдвэр 188,2 сая төгрөгийн төмөр эдлэлийг 2005 оны 7-11 дүгээр сард “Молор трейд” ХХК-нд зээлээр олгожээ. УНДЕГ “Молор трейд” ХХК-аас орон сууц худалдан авах гэрээ хийж, 2005 оны 7 дугаар сараас 2006 оны 1 дүгээр сарын хооронд бүгд 417,8 сая төгрөгийг олгоод байгаа боловч 2005 оны 11 дүгээр сараас хойш тухайн барилгын ажил зогсчээ.

Үүний дараа “Марагал” ХХК НДШ-ийн хуримтлагдсан өр төлбөр барагдуулсан гэж урамшуулалд 10,8 сая төгрөг авчээ.

Дээрх байдал “Бэрх уул” ХК-ний НДШ-ийн өрийг барагдуулахад мөн давтагдаж, УНДЕГ-ын даргын шийдвэрээр Хэнтий аймгийн НДХ-ээс “Марагал” ХХК-д 16,8 сая төгрөгийн урамшил олгожээ.

УНДЕГ хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ бүрэн биелүүлэлгүй, “Марагал” ХХК-д 2005 онд бүгд 46,5 сая төгрөгийг НДС-гаас олгож, НДС-гийн хөрөнгийг үрэлгэн зарцуулжээ.

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын санхүүжилт, түүний зарцуулалт

5. Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хянах, батлах

УИХ-ын 2004 оны 14 дүгээр тогтоолд зааснаар УНДЕГ нь НХХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд ТБУСТХ-ийн дагуу УНДЕГ-ын дарга НХХ-ийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай Үр дүнгийн гэрээ байгуулж ажиллаж байна.

Гэхдээ НДТХ-ийн 31-т заасны дагуу НД-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг НДС-гаас санхүүжүүлэх бөгөөд НДҮЗ жил бүр санхүү, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний саналыг үндэслэн баталж байх ёстой.

Гэвч НДҮЗ 2005 оны турш үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг 6 удаа нэмж, тодотгохдоо холбогдох саналыг тухай бүр авч байгаагүй байна.

Нийгмийн даатгалын зардлын талаар гарсан шийдвэр, өгсөн саналын харьцуулалт

(сая төгрөгөөр)

Төсөв баталсан шийдвэр ба өгсөн санал	Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалт	Бүгд дүн
УИХ-аас баталсан (2005 оны Төсвийн тухай хууль)	2355.5	Төсөвт тусгаагүй	2355.5
Сангийн сайдын санал	2355.5	1586.1	3941.6
НХХ-ийн сайдын санал	3694.8	1172.8	4867.6
НДҮЗ-ийн тогтоолоор	3773.6	2855.8	6766,1

Эндээс үзэхэд НД-ын 2005 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсөв Сангийн сайдын саналаас 72%-иар, НХХ-ийн сайдын саналаас 39%-иар тус тус хэтэрсэн төдийгүй, УИХ-аас баталсан Монгол Улсын 2005 оны нэгдсэн төсвийн тухай хуульд тусгагдсанаас 2,9 дахин их байна.

Дүгнэлт

- **НД-ын хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын талаар НДҮЗ-өөс гаргаж байгаа шийдвэр УИХ-аас баталсан хуультай нийцэхгүй байна.**
- **НДҮЗ нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардал болон хөрөнгө оруулалтыг хянаж батлахдаа холбогдох хууль тогтоомжийг баримтлаагүй байна**

Үндсэн хуулийн 19.1 дэх заалт буюу “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхөө өмнө хариуцна” гэж заасныг үндэслэн цаашид НД-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх боломжийг судалж, шийдвэрлэх нь зүйтэй байна.

Энэ нь Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “Нийгмийн халамжийн доод хэм, хэмжээний тухай” конвенцийн үзэл баримтлалтай үл зөрчилдөх бөгөөд ингэснээр НД-ын байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоо ТБУСТХ-ийн зарчимд бүрэн нийцэх юм.

Төсвийг боловсруулах, хянах, батлахад арвилан хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлаагүй байна.

НДТХ-иар хүлээсэн чиг үүргийн дагуу НДҮЗ тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх талаар 2005 онд нэг ч асуудал тавьж байгаагүй мөртлөө өмнөх онтой харьцуулснаар НД-ын байгууллагын зардлыг 1,6 дахин, хөрөнгө оруулалтын зардлыг 2,1 дахин буюу нийт зардлыг 2,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргажээ.

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны
зардлын санхүүжилт, түүний зарцуулалт

үргэлжлэл

НД-ын байгууллагын
зардлын судалгаа
(сая төгрөгөөр)

Батлагдсан зардал	2003 он	2004 он	2005 он	2006 он
Үйл ажиллагааны зардал	2368,1	2640,6	4708,5	2151,1
Хөрөнгө оруулалтын зардал	498,8	2446,0	2057,5	1049,6
Нийт зардал	2866,9	5086,6	6766,1	3200,7
НДС-гийн орлого бүрдэлт	96764,7	157338,8	176349,9	198387,3
Нийт зардлын НДС-гийн нийт орлогод эзлэх хувийн жин	3,0%	3,2%	4,0%	1,6%

2006 онд өмнөх оны гүйцэтгэлээс 3565,4 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин бага төсөв баталсан байх боловч НДС-гийн хөрөнгийг арвилан хэмнэх боломжийг эрж хайгаагүй байна.

НДС-гаас 2005 онд ажил олгогчдын урамшуулалд болон банкны үйлчилгээний хөлсөнд олгосон хөрөнгөөс тайланд онд 89,1 сая төгрөг зарцуулагдалгүй үлджээ. Үүнийг дараа онд тэдгээр зардалд зориулан НДС-гаас санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт тооцож, батлагдсан төсвийг залруулах нь зүйтэй юм.

УНДЕГ 2004 онд Барилга корпорациас хувьцаа худалдан авах замаар 108 айлын орон сууц бариулж НДҮЗ-ийн шийдвэрээр үнийн 60%-д хөнгөлөлт үзүүлж, НДС-гаас төлжээ. Гэтэл барилга ашиглалтад орсны дараа талбайн зөрүү гэж 49,5 сая төгрөг нэхэмжлэхэд НДҮЗ уг хөрөнгийг НДС-гаас төлүүлэхээр шийдвэр гаргажээ. Энэ үнийн дүнгийн 40%-ийг орон сууц эзэмшигчдээр нөхөн төлүүлж, НДС-д төвлөрүүлэх нь зүйтэй байна.

6. Олгогдсон санхүүжилтийг захиран зарцуулж байгаа байдал

НДҮЗ-өөс 2005 оны батлагдсан төсвийг НДС-гаас бүрэн татан авсан бөгөөд авсан санхүүжилтээс 530,4 сая төгрөг батлагдсан зориулалтын

дагуу зарцуулагдалгүй үлджээ. (*Хавсралт № 2-ыг үзнэ үү*)

Зарцуулагдаагүй хөрөнгөөс 260 сая төгрөг нь Өмнөговь, Говьсүмбэр аймаг болон Багануур дүүргийн НДХ-ийн конторын барилгын ажлын санхүүжилтээс тайлант онд төлөгдөөгүй үлдэгдэл бөгөөд бусдыг нь буюу 69,0 сая төгрөгийг ажиллагсдад орон сууцны хөнгөлөлт үзүүлэх, 87,4 сая төгрөгийг компьютерийн дэлгэц худалдан авах, 46,0 сая төгрөгийг Сүхбаатар дүүргийн НДХ-ийн конторын барилгыг санхүүжүүлэхэд зарцуулж, холбогдох шийдвэрийг дараа онд НДҮЗ-өөр нөхөн гаргуулахаар тооцжээ.

Санхүүжилтээр олгогдсон хөрөнгийг захиран зарцуулагдсан байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ:

- Тендер шалгаруулалгүй НДС-гийн 2003, 2004 оны санхүүгийн нэгдсэн тайланд хөрвүүлэлт хийлгэх, аудитын дүгнэлт гаргуулах 55,0 сая төгрөгийн гэрээг “НИММ Аудит” ХХК-тай байгуулж, 2005 онд хийлгүүлжээ. Ингэхдээ бодитой хэрэгцээ шаардлага өнгөрсөн байхад 2003 оны санхүүгийн тайланд хөрвүүлэлт хийлгүүлэхэд 13,6 сая төгрөг, аудитын дүгнэлт гаргуулахад 13,6 сая төгрөг тус тус зарцуулжээ.
- 2005 оны 2 дугаар сард “Хэт” ХХК-иас 58,2 сая төгрөгийн үнэтэй автомашиныг тендер шалгаруулалгүй, шууд гэрээ байгуулж, худалдан авч, НХХ-ийн сайдын хөдөө ажлын зориулалтаар ашиглуулахаар НХХЯ-ны ТНБД-тай гэрээ хийж хүлээлгэн өгөхдөө ТӨХ-ноос холбогдох шийдвэр, зөвшөөрөл аваагүй байна.
- Хяналт шалгалтын байцаагчийг ажил үүрэгтэй нь огт холбоогүй чиглэлээр буюу удирдлагын нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр АНУ-д 36 цагийн сургалтад суралцуулахын тулд 6,0 сая төгрөг зарцуулжээ.

**Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны
зардлын санхүүжилт, түүний зарцуулалт**

үргэлжлэл

- Архангай аймгийн НДХ НДШ-ийн төлбөрт хураан авсан объектыг худалдан борлуулж, НДС-ын орлогыг бүрдүүлэх байтал өөрөө нүүн ирж, байрласнаас тус хэлтсийн эзэмшлийн 17,5 сая төгрөгийн албан конторын барилга ямар ч ашиглалтгүй болсон байна.
- Тендер шалгаруулалгүй “Шилмэл загвар” ХХК-иар 75,8 сая төгрөгийн дүрэмт хувцас нэгдсэн журмаар хийлгэхдээ иргэн Тунгалаг, Батдорж нартай гэрээ хийж, дүрэмт хувцасны нэмэлт тоноглол (энгэрийн тэмдэг, товч, нэрийн зүүлт зэрэг) -д 34,7 сая төгрөг нэмж зарцуулж, үрэлгэн загнажээ.

Ийнхүү УНДЕГ НДС-гаас олгосон санхүүжилтийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар, холбогдох шийдвэргүй захиран зарцуулсан тохиолдол нилээд гарчээ.

УНДЕГ, Нийслэлийн НД-ын газар, аймаг, дүүргийн НДХ-үүдэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг Хавсралт №3-аас үзнэ үү.

7. Худалдан авалтад тендер шалгаруулсан байдал

УНДЕГ 2005 онд 23 удаагийн 1223,2 сая төгрөгийн худалдан авалтад холбогдох хууль тогтоомжийн дагуу тендер шалгаруулалт явуулалгүй, гүйцэтгэгчийг шууд сонгожээ. (Хавсралт №4 -ийг үзнэ үү).

Тухайлбал:

- 2005 оны 6 дугаар сард байгуулагдаж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан “Натурфурнитур” ХХК-тай бүгд 139,0 сая төгрөгийн үнийн дүн бүхий албан өрөөний тавилга худалдан авах 3 гэрээг 2005 оны 6 дугаар сарын 20-23-нд байгуулж, 7 хоногийн дотор мөнгийг бүрэн олгожээ. Тус компани 2005 оны 8 дугаар сарын 22-нд тавилгын гааль, НӨТ, тээврийн зардалд 28,2 сая төгрөг нэхэмжилснийг 8 дугаар сарын 23-нд шилжүүлсэн байх бөгөөд гэрээт тавилга 8 дугаар сарын 29-нд УНДЕГ-т нийлүүлэгджээ. Энэ нь байгуулсан

гэрээний үнийн дүнгээс хэтэрсэн, холбогдох анхан шатны баримтын бүрдэлгүй байна.

- УНДЕГ-ын даргын тушаалаар сумдыг тэтгэврийн дэвтэр хадгалах сейфээр хангахаар шийдвэрлэж, үнэ, тоо, хуваарийг батлан, түүний үндсэн дээр аймгийн НДХ-үүдэд 92,6 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Аймаг, дүүргийн НДХ-үүдэд хийсэн аудитын тайлангаас үзэхэд сейфний үнийн санхүүжилтийг НДХ-үүд УНДЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу “Батбуянт фаянэнс” хоршоо руу шилжүүлж, сейф худалдан авчээ. “Батбуянт фаянэнс” хоршоо нь хадгаламж, зээлийн болон бэлэн мөнгө гаргах үйлчилгээ эрхэлдэг байгууллага бөгөөд УНДЕГ сейфний худалдан авалттай холбоотой тендер шалгаруулалт явуулаагүй, ямар нэгэн гэрээ хэлцэл ч байгуулаагүй байна.
- УНДЕГ 2005 онд өөрийн харьяа байгууллагууддаа “Молор трейд” ХХК-иас 7,0 сая, “Эвт” ХХК-иас 10,2 сая, “Өрнөл трейд” ХХК-иас 12,0 сая, “Наранбулаг хан” ХХК-иас 9,0 сая, “Батбуянт фаянэнс” хоршооноос 9,0 сая төгрөгөөр тус тус автомашин худалдан авахдаа тендер шалгаруулалт явуулаагүй байна.

УНДЕГ-ын удирдлага тушаал гаргаж, ажилд авсан хүнтэйгээ 499,0 сая төгрөгийн гэрээ байгуулахдаа тендер шалгаруулаагүй төдийгүй, нэмж 135,4 сая төгрөгийг холбогдох гэрээ хэлцэлгүй шилжүүлж, 188,2 сая төгрөгийн материалыг зээлээр ашиглуулж байна

- УНДЕГ 2005 оны 7 дугаар сард “Молор трейд” ХХК-ний орон сууцны барилгаас 30 айлын орон сууцыг 499,0 сая төгрөгөөр бариулж, 2005 оны 3 дугаар сарын 25-ны дотор хүлээн авахаар гүйцэтгэх захирал Л.Бадамцэцэгтэй “Хамтран ажиллах гэрээ №А/01”-ийг байгуулжээ. Гэрээний дагуу УНДЕГ 260,0 сая төгрөгийг шууд шилжүүлж, үлдэх 239,0 сая төгрөгийг байгууллагаас баталгаа гарган, ХААН

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны
зардлын санхүүжилт, түүний зарцуулалт

үргэлжлэл

банкнаас орон сууц авах ажиллагсдын нэр дээр зээл авахуулан, төлүүлжээ. Үүнээс гадна 2005 оны 7 дугаар сараас 10 дугаар сарын хооронд Дарханы Төмөрлөгийн үйлдвэрээс 188,2 сая төгрөгийн арматурын төмрийг тус компанид олгуулаад байгаа билээ.



Баригдах 90 айлын орон сууцны барилгын зураг

УНДЕГ-ын холбогдох албан тушаалтнууд байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу барилгын ажлын явц байдлыг хянаж байх үүргээ огт биелүүлээгүйгээр барахгүй барилгын ажил 2005 оны 11 дүгээр сараас хойш зогссон байхад 2005 оны сүүлээр 22,4 сая төгрөг, 2006 оны 2 дугаар сард 135,4 сая төгрөгийг “Молор трейд” ХХК руу нэмж шилжүүлсэн байх бөгөөд эдгээр төлбөртэй холбоотой гэрээ, хэлцэл алга байна.

Өнөөдрийн байдлаар 90 айлын орон сууцны 70 гаруй хувийнх нь үнэ буюу 845,1 сая төгрөг НДС-гийн хөрөнгөөр болон НД-ын байгууллагад ажиллагсдын Улаанбаатар банкнаас авсан зээлээр төлөгдөөд байгаа боловч “Молор трейд” ХХК-ний тодорхойлсноор барилгын ажил 2005 оны 11 дүгээр сараас түр зогсжээ. Уг 9 давхар орон сууцны барилгын 6 давхрын өрлөг бүрэн хийгдээгүй байгаагаас үзэхэд гэрээт хугацаанд буюу 2006 оны 3 дугаар сард ашиглалтад орох ямар ч боломжгүй байна



Барилгын ажлын явн (орц талаас)
2006/03/14-ний өдөр



Барилгын ажлын явн (зүүн талаас)
2006/03/14-ний өдөр

УНДЕГ-тай “Хамтран ажиллах гэрээ №А/01”-ийг байгуулсан Л.Бадамцэцэг өмнө нь “Молор трейд” ХХК-ний аж ахуйн албаны дарга гэж 2005 оны 1 дүгээр сард түрээсийн тухай Гэрээ05/09-ийг УНДЕГ-тай байгуулж байжээ.

УНДЕГ-ын даргын 2005 оны 118 дугаар тушаалаар 2005 оны 5 дугаар сарын 17-ноос тус газрын харьяа “Залаат” амралтын газрын захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон Лувсанжамц овогтой Бадамцэцэг нь УНДЕГ-тай дээрх 2 гэрээг байгуулсан Л.Бадамцэцэг болох нь тодорхой байна.

**УНДЕГ нөхцөл, шаардлага хангахгүй
объектыг өндөр үнээр худалдан авчээ**

- УНДЕГ-ын харьяа МӨСЭХМТ 2005 оны 3 дугаар сард Улаанбаатар хот, ойрын аймаг, орон нутаг, үйлдвэр байгууллагуудын мэргэжлийн өвчтэй хүмүүсийг эмчлэн сувилах мэргэжлийн өвчний төвийн сувилал байгуулан ажиллуулах шаардлагыг уламжилж, 25 ортой сувилал байгуулан ажиллуулах тооцоо судалгаа, төслийг боловсруулж, УНДЕГ-т хүргүүлжээ. Уг төсөлд сувиллын газар нь цэвэр бохир усны системд холбогдсон, тус бүрдээ 4 ортой сувилуулагчдын өрөө 10, үзлэг, эмчилгээ, оношилгооны 9 өрөө, шавар болон усан эмчилгээний кабинеттай, гал тогоо, агуулах болон сантехникийн 12 өрөө, соёлын танхим, амрах заал зэрэг нийт 30 гаруй өрөө, тасалгаатай 572 м² ашигтай талбайтай, тохижилт, цэцэрлэгжилт бүхий 400 м² гадна талбайтай байх шаардлагыг тодорхойлжээ.

НДҮЗ-ийн 2005 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 23 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын хөрөнгө оруулалтын зардлын төсөвт тодотгол хийхдээ МӨСЭХМТ-д сувиллын газар худалдан авахад 90,0 сая төгрөг баталсан бөгөөд УНДЕГ холбогдох тендер шалгаруулалтыг явуулахдаа ТБОНӨХХАБАҮГСЖТХ-ийн 38.3.3-т “бараа, үйлчилгээний төсөвт өртөг 50’000’001-100’000’000, ажлын төсөвт өртөг 75’000’001-150’000’000 төгрөг байхаар бол яамны тендерийн хороо” –г байгуулах талаар заасан заалтыг зөрчиж, УНДЕГ-ын Тендерийн хороогоор шийдүүлжээ.

Өрсөлдөх санал ирээгүй гэдэг үндэслэлээр тус тендерийн хорооны шийдвэрээр “Таван загал” ХХК-ниас Хандгайт дахь “Сантаун” амралтын газрыг 75,0 сая төгрөгөөр шууд худалдан авчээ. Ингэхдээ холбогдох хуульд заасны дагуу үнийн саналыг техникийн тодорхойлолт болон бусад болзолтой нийцэж байгаа эсэхийг болон санал болгосон үнэ бодитой өрсөлдөх чадвартай эсэхийг хянан үзээгүй байна.

“Сантаун” амралтын газар өмнө нь “Молор трейд” ХХК-ний эзэмшилд ашиглагдаж байсан бөгөөд гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2005 оны 3 дугаар сард байгуулагдсан “Таван загал” ХХК 2005 оны 10 дугаар сарын 26-ны өдөр буюу анх тендерийн зар нийтлэгдсэнээс хойш 15 хоногийн дараа “Сантаун” амралтын газрыг өмчлөх эрхийг шилжүүлэн авч, үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн Ү-2203009436 дугаар авсан байна.



“Сантаун” амралт
(наад талын ягаан байшин, гэрүүд)



“Сантаун” амралтын байшин, төмөр хашаа



“Сантаун” амралтын 5 гэр, модон хашаатайгаа

Уг “Сантаун” амралтын газар нь 8 м х 35 м хэмжээтэй, дотроо 12 өрөө бүхий хуучин тоосгон байшин, тус бүр нь дотроо 5 ортой 5 гэр бүхий гадуураа намхан хашаатай, цэвэр бохир усны системд холбогдоогүй, усан болон шавар эмчилгээ явуулах боломжгүй, айлуудын дунд байрлаж байгаа учир “дуу чимээгүй, нам гүм, утаа униаргүй, цэвэр байгалийн орчинд” байх талаар тендерийн бичиг баримтад тодорхойлсон ерөнхий нөхцөлийг хангахгүй байна.

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын санхүүжилт, түүний зарцуулалт**Дүгнэлт**

УНДЕГ 2005 онд “Молор трейд” ХХК-иас удаа дараа бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, уг компаний бариулж байгаа орон сууцны барилгад их хэмжээний хөрөнгө урьдчилан олгоод байгаа, мөн эзэмшиж байсан объектыг нь хэрэгцээ, шаардлага хангахгүй байхад өндөр үнээр худалдан авсан, компанийг төлөөлдөг удирдах ажилтныг нь тушаал гаргаж ажилд авсны дараа өндөр дүнтэй гэрээ байгуулсан зэргээс үзэхэд тус газрын удирдлага “Молор трейд” ХХК-тай нэгдмэл ашиг сонирхолтой байж болзошгүй байна.

Санхүүгийн нэгдсэн тайлан бүрэн нэгтгэгдээгүй байна**А. “Маягтны” гэх санхүүгийн тайлан**

УНДЕГ нь НД-ын үйл ажиллагаанд хэрэглэгддэг маягт (НД-ын дэвтэр, ЭМД-ын дэвтэр, тэтгэврийн дэвтэр, тэтгэврийн хувийн хэрэг, эмнэлгийн хуудас г.м.) болон түүнтэй холбоотой төлбөр, тооцоог “маягтны” гэх тусгайлсан данс, тооцоогоор дамжуулан бүртгэж иржээ.

Аймаг, дүүргийн НДХ-үүд маягтын тайлан тооцоог тусгайлан УНДЕГ-т ирүүлснийг нэгтгэж, нэгдсэн тайлан бэлтгэж байгаа боловч НДС-гийн болон үйл ажиллагааны санхүүгийн нэгдсэн тайлангийн алинд ч нэгтгэж байгаагүйгээс холбогдох санхүүгийн мэдээлэл дээд шатны санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.

2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус маягтны гэх дансны арилжааны банкууд дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 413,8 сая төгрөг, данс бүртгэлд тусгагдсан маягтны үнийн дүн 508,0 сая төгрөг болоод байна.

Доорхи үндэслэлийн дагуу “Маягтны” гэх дансны бүртгэл тооцоо, санхүүгийн тайланг НДС-гийн санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэн, тайлагнаж байх. Үүнд:

- *Маягтны худалдан авалт болон түүний борлуулалтаас төвлөрсөн хөрөнгийг НДҮЗ-өөс хянаж байх боломжтой болно*
- *Маягт хэвлүүлэх анхны хөрөнгийн эх үүсвэрийг НДС-гаас санхүүжүүлж байсан*
- *Маягттай холбоотой хөрөнгө, зардал нь НД-ын байгууллагуудад бус харин даатгуулагчдад илүү хамааралтай*

Б. МӨСЭХМТ-ийн санхүүгийн тайлан

МӨСЭХМТ нь УНДЕГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулдаг, НДҮЗ-ийн шийдвэрээр НДС-гаас санхүүждэг байгууллага бөгөөд тус төвийн захирлыг УНДЕГ-ын дарга томилж, ТБУСТХ-ийн дагуу үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэж иржээ.

Тус төв урьд өмнө санхүүгийн тайлангаа гаргаж УНДЕГ-т тушааж байсан боловч НХХЯ болон УНДЕГ-ын санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдэж байгаагүй байна.

2005 онд тус төв НДС-гаас бүгд 221,8 сая төгрөгийн санхүүжилт авч, хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардалд зарцуулсан бөгөөд оны эцсийн байдлаар 352,9 сая төгрөгийн үндсэн болон эргэлтийн хөрөнгөтэй байна.

НДС-гийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулж байна

Тайлант жилд УНДЕГ дээрх данснаас 332,8 сая төгрөгийн худалдан авалт хийсний 290,6 сая төгрөгийг нийгмийн даатгалын маягт хийлгэж, үлдэх 42,1 сая төгрөгийг НДҮЗ-өөс батлагдаагүй, төдийлөн үр ашиг багатай худалдан авалтад зарцуулжээ. Тодруулбал, 18,5 сая төгрөгийг 6000 ширхэг хуулийн эмхэтгэл хэвлүүлэхэд, 3,0 сая төгрөгийг хуулийн эмхэтгэлийг электрон байдлаар 3000 ширхэг хувилуулахад, 8,0 сая төгрөгийг нийгмийн даатгалын сүлд дуутэй клип бүхий “Перпект” хамтлагийн DVD-г 2000 хувь хийлгэхэд, 12,6 сая төгрөгийг ажлын хувцасны нэмэлт тоноглол хийлгэхэд зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлын санхүүжилт, түүний зарцуулалт

үргэлжлэл

УНДЕГ 90,0 сая төгрөгөөр НД-ын дэвтэр, 54,0 сая төгрөгөөр тэтгэврийн дэвтэр хэвлүүлэхдээ холбогдох хуулийн дагуу яам дундын тендерийн хороогоор биш өөрийн байгууллагын тендерийн хороогоор тендер шалгаруулалтыг зохион байгуулжээ.

НД-ын дэвтэр 300000 ширхэг, ЭМД-ын дэвтэр 600000 ширхэгийг хэвлүүлэх тендер шалгаруулалтад “Бит пресс” ХХК-ийг сонгож бүгд 150,0 сая төгрөг төлсөн бөгөөд энэ нь хоёр тендерт тус бүрд нь ирүүлсэн хамгийн бага үнийн саналаар тооцсон дүнгээс 38,2 сая төгрөгөөр илүү байна.

Хууль, эрх зүйн орчны өөрчлөлт зэрэг ирээдүйд гарч болзошгүй нөхцөл байдлыг тооцож үзсэн ч, НДС-гийн хөрөнгийг аль болох үр ашигтай, арвилан хэмнэлттэй захиран зарцуулж, өсгөж арвижуулах бодлогын хувьд ч маягтыг нэг дор их хэмжээгээр хэвлүүлж бэлтгэх нь эрсдэлтэй, оновчгүй шийдвэр гэж үзэж байна.

УНДЕГ НДҮЗ-ийн баталсан хөрөнгийг 2005 оны 2 дугаар сард НДС-гаас тусгаарлан авч Улаанбаатар банкинд 1,5 тэрбум төгрөгийг сарын 1 хувийн хүүтэй хадгалуулснаар бүгд 77,6 сая төгрөгийн хүүгийн орлого олжээ. Энэ нь СЭЗ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2003 оны 45/21 дугаар тушаалаар батлагдсан “НДС, НД-ын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх журам”-ын 2.8-т “НД-ын байгууллага нь СЭЗ-ийн сайдын тусгай зөвшөөрөлгүйгээр төрийн сангаас гадуур банк болон санхүүгийн байгууллагад данс нээхийг хориглоно” гэж заасныг зөрчжээ.

Дүгнэлт

УНДЕГ НД-ын байгууллагын хөрөнгийг арилжааны банкинд байршуулсан нь дээрх журмыг зөрчиж байна.

8. Өөрийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт

НДҮЗ нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлын төсвийг батлахдаа зохих хэсгийг өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлж байхаар төлөвлөгөө баталж өгдөг.

Энэ нь ерөнхийдөө холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт шалгалтаар тогтоосон алдангийн төлбөрийн орлого урамшуулал, ашиглалтгүй байр, талбайн түрээсийн орлогоос бүрддэг.

Өөрийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт

(сая төгрөгөөр)

Өөрийн үйл ажиллагааны орлого	2004 он	2005 он	Зөрүү	
			дүн	Хувь
Төлөвлөгөө	239,9	258,0	18,1	8,0%
Гүйцэтгэл	904,8	336,4	94,6	39,0%
Үүнээс:				
- хүүгийн орлого	6,7	80,1	73,4	1096,0%
- түрээсийн орлого	44,5	36,5	-8,0	-18,0%
- алдангийн 20%	165,4	167,8	2,4	1,5%
- бусад орлого	25,2	46,4	641,8	-93,0%

Удирдлагын үйл ажиллагаа

9. Орон тоо, бүтэц, боловсон хүчний сонгон шалгаруулалт

НДҮЗ-ийн 2000 оны 6 дугаар тогтоолоор УНДЕГ-ын бүтэц, орон тоог баталсан бөгөөд уг тогтоол хүчин төгөлдөр байсаар атал УНДЕГ-ын даргын 2005 оны 1 дүгээр тушаалаар тус газрын бүтцэд хамаарах хэлтэс, орон тоо, албан тушаалын жагсаалтыг өөрчлөн баталж, 2005 оны 3 дугаар улирал хүртэл мөрдсөн нь НДҮЗ-ийн бүрэн эрхийн талаар НДТХ-ийн 4 дүгээр бүлгийн 27.6-т “НД-ын төв байгууллагын бүтэц, ... төсвийг батална” гэснийг зөрчжээ.

Дээрх тушаалаар нийслэлийн НД-ын газрын Хяналт, шалгалтын хэлтсийг УНДЕГ-ын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэстэй нэгтгэж, Хяналт, үнэлгээний хэлтэс байгуулах замаар НД-ын дотоод хяналтыг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-т “...зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын сайд батална...” гэсэн заалтыг үндэслэн НХХ-ийн сайдын 2005 оны 112 дугаар тушаалаар хэрэгжүүлэгч агентлаг УНДЕГ-ын удирдлага, бүтцийг тогтоож, салбарын нийт ажиллагсдын орон тооны дээд хязгаарыг 1150 байхаар баталсан нь НДТХ-ийн 27 дугаар зүйлийн 3.6 дахь заалттай зөрчилдөж байна. (Хавсралт №5-ыг үзнэ үү)

Иргэний хуулийн 3.3-т хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэхийг заасны дагуу НДҮЗ-ийн баталсан бүтцийг мөрдөх нь зүйтэй байна.

Дүгнэлт

УНДЕГ орон тоо, бүтцийг шинэчлэхдээ холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй байна.

НД-ын байгууллагын орон тоог оновчтой нэмээгүй байна

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс тогтоосон нормативын дагуу орон тоо зохион байгуулаагүйгээс ажлын ачаалал хэт ихэсч байгаа талаар дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмж өгч байжээ.

УНДЕГ-ын ҮЭ-ийн байгууллагатай байгуулсан “Хамтын хэлэлцээр” болон УНДЕГ-ын даргын 2002 оны 75 дугаар тушаалаар тогтоосон НД-ын байгууллагын ажилтны хариуцан гүйцэтгэх ажлын нормын дагуу тооцож үзвэл 2005 оны эцсийн байдлаар байцаагчдын орон тоо 56-аар бага байна.

НД-ын байцаагчдын орон тооны судалгаа

Байцаагч, даатгуулагчдын тоо	Даатгуулагчийн тоо	Байцаагчийн тоо		Зөрүү
		Байвал зохих	Одоо байгаа	
Шимтгэлийн байцаагч (4000 даатгуулагчид)	710768	178	195	-43
Гэтгэврийн байцаагч (3000 тэтгэвэр авагчид 1)	179959	60		
Хяналт шалгалтын байцаагчид (200 ажил олгогчид 1)	16685	84	57	-63
Гэтгэвэр, тэтгэмжийн хяналт шалгалтын байцаагчид (5000 тэтгэвэр авагчид 1)	179959	36		
ЭМД-ын байцаагч (80000 даатгуулагчид 1)	1185025	15	28	13
Магадлагч эмч (80000 даатгуулагчид 1)	1185025	15	27	12
Сайн дурын байцаагч			7	25
Нэрийн дансны байцаагч			2	
Оператор			16	
Бүгд дүн		388	332	-56

2005 онд НД-ын байгууллагуудын салбарын хэмжээнд бүгд 189 ажилтан шинээр ажилд орсны 36 нь УНДЕГ-ын захиргааны хэлтэст шинээр 3 алба байгуулсантай, 30 нь НДХ-үүдэд орлогч даргын албан тушаалыг бий болгосонтой холбоотой байна.

Удирдлагын үйл ажиллагаа

үргэлжлэл

Шинээр нэмэгдсэн ажлын байрууд нь нийгмийн даатгалын ажил үйлчилгээнд шууд хамааралгүй өөрөөр хэлбэл хөдөлмөрийн нормын дагуу байцаагчийн орон тоо биш, ихэнх нь захиргаа удирдлага, аж ахуйн шинжтэй, түүнийг дагалдах ажлын байрууд байх бөгөөд зарим тохиолдолд өмнө байсан ажил үүргийг хэт жижигрүүлж салгаж, олшруулжээ.

Дүгнэлт

УНДЕГ 2005 онд батлагдсан дээд хязгаарт багтаан орон тоо нэмсэн боловч НДТХ-иар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн орон тоог оновчтой нэмээгүй байна

Боловсон хүчнийг сонгон шалгаруулж байгаагүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 7.1.7-т зааснаар УНДЕГ-ын удирдлага болон гүйцэтгэх албан тушаалтан төрийн захиргааны албан тушаалын ангилалд багтах бөгөөд мөн хуулийн 17.1-т “...сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхөх” гэж заасныг мөрдөөгүй байна.

Гэтэл УНДЕГ-ын дарга, орлогч даргаас бусад гүйцэтгэх албан тушаалтнуудыг Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд хамааруулж ирсэн нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

1. Ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэж буй байдал

НДҮЗ-ийн 2001 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн “НД-ын байгууллага, байцаагч, ажилтан, ажил олгогч нарт хяналт шалгалтын орлогоос шагнал, дэмжлэг, туслалцаа үзүүлэх тухай журам”-ыг УНДЕГ-ын даргын 2001 оны 116 дугаар тушаалаар баталж, хэрэгжүүлж иржээ.

НД-ын дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, өөрийн хариуцсан ажилдаа алдаа дутагдал

гаргаагүй НД-ын байцаагч, ажилтныг түүний хяналт шалгалтаар НДС-д оруулсан орлогоос 10 хүртэл хувиар улиралд нэг удаа шагнаж урамшуулах ба урамшууллын хэмжээ нь тухайн хүний жилийн үндсэн цалингийн дүнгээс хэтрэхгүй байхаар заасны дагуу 2005 онд НД-ын 32 байцаагчид 4,9 сая төгрөгийн урамшуулал олгожээ.

НДҮЗ-өөс баталсан хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2004 онд бүгд 108 айлын орон сууцны 2 барилга бариулж, үнийн дүнгийн 60% буюу 1093,1 сая төгрөгийг НДС-гийн хөрөнгөөр, үлдэх 40% буюу 728,7 сая төгрөгийг АХБ-ны орон сууцны урт хугацаатай зээлийн хөтөлбөрт орон сууцанд орсон ажиллагсдыг хамруулан төлүүлжээ.

Үүнээс гадна 12 ажилтанд орон сууцны дэмжлэг болгож 32,0 сая төгрөг олгосноор мөн онд бүгд 120 ажилтанд 1125,0 сая төгрөгийн дэмжлэг олгосон нь дунджаар 1 хүнд 9,4 сая төгрөг ногджээ.

2005 онд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 99 ажилтанд 697,5 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг олгосон нь дунджаар 1 хүнд 7,0 сая төгрөг ногдож байна.

Сүүлийн 2 жилд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 219 ажилтанд бүгд 1,8 тэрбум төгрөгийг орон сууцны хөнгөлөлтөд тодорхой шалгуур, батлагдсан журамгүй олгожээ.

Иймд НД-ын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцны хөнгөлөлт олгоход баримтлах дотоод журам боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

2. Үндсэн чиглэлийн зорилтыг хангуулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр нөлөө

Үндсэн чиглэлийн зорилтыг хангуулахаар 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн нэрийн дансыг нээх, гарааны үлдэгдэл тооцох, тухайн жилд төлсөн шимтгэлийг бүртгэх, даатгуулагчид мэдээлэх хуудас хүргүүлэх, шилжүүлэг хийх үйл ажиллагааг төв, орон нутгийн НД-ын байгууллага эрхлэн гүйцэтгэж байна.

Даатгуулагчийн нэрийн дансны орлогод хүү тооцох, нэрийн дансны мэдээлэх хуудсыг

Удирдлагын үйл ажиллагаа

үргэлжлэл

даатгуулагч бүрээр хэвлэх, нэрийн данс нээсэн даатгуулагчийн тоо, бүртгэгдсэн хөрөнгийн хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах ажлыг УНДЕГ-ын Мэдээлэл, технологийн төв эрхлэн гүйцэтгэж байна.

НДС-гийн Windows орчны нягтлан бодох бүртгэлийн багц программ хангамж боловсруулан дуусгаж, 2006 оноос эхлэн нэвтрүүлэхээр эхний үлдэгдлийг программд оруулж эхлээд байна. Ингэхдээ Монгол Улсын нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжид заасан НДС-гийн салбарын онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг “НИММ аудит” ХХК-иар 50,0 сая төгрөгөөр захиалан хийлгүүлж, Сангийн сайд, НХХ-ийн сайдын 2006 оны 18/03 дугаар тушаалаар батлуулан, мөрдөж ажиллахад бэлэн болжээ.

Хувиараа хөдөлмөр эрхлэх замаар үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлж байгаа иргэдийг НДС-д сайн дураар нь хамруулах зорилгоор төв, орон нутгийн албадад хууль сурталчлах ажлыг зохион байгуулснаар энэ төрлийн даатгуулагчдын тоо 29,3 мянгад хүрч, жилдээ 1,1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, улмаар НДС-гаас тэтгэвэр, тэтгэмж авах нөхцөлөөр хангажээ.

Дээрх үндсэн чиглэлд тусгагдсан зарчмын онцлог асуудал болох НДС-ын хувийн хэвшлийн тогтолцоог бий болгох асуудал судалгааны шатанд явагдаж байна.

Дотоод хяналтын тогтолцоо

3. Дотоод хяналтын тогтолцоо, чиг үүрэг

2000 онд Төрийн хянан шалгах хорооноос (тухайн үеийн нэрээр) УНДЕГ, түүний системийн зарим байгууллагад хийсэн шалгалтаас өгсөн зөвлөмжийн мөрөөр УНДЕГ-ын бүтцэд Хяналт, шалгалт үнэлгээний хэлтсийг байгуулжээ. Улмаар 2005 онд тус хэлтэст нийслэлийн НД-ын газрын Хяналт шалгалтын хэлтсийг нэгтгэж, Хяналт, үнэлгээний хэлтсийг шинэчлэн зохион байгуулжээ.

Хяналт, үнэлгээний хэлтсийн 2001 онд батлагдсан харьяа НДХ-үүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг хэвшмэл чиг үүрэгт нэмэлт, өөрчлөлт огт хийгээгүй байгаагаас үзэхэд дээрх өөрчлөлт нь дотоод хяналтын тогтолцоонд чанарын дорвитой ахиц дэвшил гаргахад үр нөлөө үзүүлээгүй байна.

Дүгнэлт

Хяналт, үнэлгээг төвлөрүүлэх байдлаар зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн боловч хэвшмэл чиг үүргийг өөрчлөөгүй, дотоод хяналтын хамрах хүрээ өргөжөөгүй байна.

Хяналт шалгалтын ажлын үр өгөөж сайжирч, төлбөр зөрчлийн дүн жилээс жилд багасч байна

УНДЕГ-ын Хяналт, үнэлгээний хэлтэс НДХ-ийн үйл ажиллагааг 2 жил тутам, НДХ-үүд харьяа нэгжийн үйл ажиллагааг 2-3 жил тутам дотоод хяналт шалгалтад хамруулж иржээ.

Хяналт үнэлгээний хэлтэс шалгалтын удирдамж боловсруулахдаа тухайн НДХ-ийн үйл ажиллагааны болон орон нутгийн онцлог, ялгаатай байдлыг урьдчилан судалж үздэггүй байна.

Шалгалтын удирдамжид тусгагдсан зарим асуудлыг шалгалтын тайланд тусгаагүй зөрчил илэрч байна. Тухайлбал, зарим шалгалтын удирдамжид тухайн НДХ-ийн үнэт цаасны тооцоо, үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, программ хангамжийн талаар шалгахад тусгагдсан боловч тухайн асуудлыг

шалгасан эсэх болон шалгалтын үр дүнгийн талаар тайланд огт мэдээлээгүй байна.

Үзүүлэлтүүд	2004	2005	Зөрүү	
			дүн	хувь
Шалгалтад хамрагдсан				
- Ажил олгогчдын тоо	4'197	4'813	616	15%
- Даатгуулагчийн тоо	133'259	151'558	18299	14%
Илрүүлсэн төлбөр зөрчил бүгд: (сая төгрөгөөр)				
- тэтгэвэртэй холбоотой	114,4	121,4	7,0	6%
- тэтгэмжтэй холбоотой	96,1	60,6	-35,5	-37%
- ЭМДС-тай холбоотой	146,1	104,7	-41,4	-28%
- НДС-ийн хөрөнгөтэй холбоотой	18,1	25,4	7,3	40%

Хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчлийн хэмжээ сүүлийн жилүүдэд буурч, НДС-гийн бүрдүүлэлт, зарцуулалт, тэтгэвэр тэтгэмж тогтоолттой холбоотой зөрчлийн тохиолдол багасч байгаа нь хяналт шалгалтын ажлын үр дүн дээшилж, ажилтнуудын ажлын хариуцлага, чадвар сайжирч байгаатай холбоотой байна.

УНДЕГ дотоод хяналтын хамрах хүрээ, чиг үүргийг цаашид өргөтгөх шаардлагатай байна. Хяналт, үнэлгээний хэлтэс өнөөгийн чиг үүргээ ч хангалттай хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал, НДС-гийн орлого, зарлагын төлөвлөлт, түүний үндэслэлийг НДХ тус бүрээр судалж, шинжлэн, үнэлгээ өгч, дүгнэлт гаргах, улирал, жилийн тайлан, тэнцлийн үзүүлэлтийг нарийвчлан шалгаж, дүгнэлт гаргах, үйл ажиллагааны зардлын хэтрэлт, хэмнэлтийн байдлыг судлах, төсөв зохиох, төлөвлөхөд санал боловсруулах, мэдээллийн техник, программ хангамжийг шалгаж, дүгнэлт өгөх чиглэлээр хангалтгүй ажиллажээ.

Аудитын явцад УНДЕГ-ын Мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох зөвлөмж өгсний дагуу холбогдох дүрэм, журмыг боловсруулж, мэдээллийн нууцлал, системийн хамгаалалт, аюулгүй байдлыг дээшлүүлсэн байна.

Тэтгэвэр, тэтгэмж олголт**4. Тэтгэвэр, тэтгэмж олголт, өрийн
үлдэгдэл, барагдүүлалт**

*НД-аас олгогдох тэтгэвэр, тэтгэмж цаг
хугацаандаа, бүрэн олгогдож иржээ*

НДС-гаас 2005 онд олговол зохих өндөр насны тэтгэвэр болон тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэмжийн 113,7 тэрбум төгрөг, цэргийн алба хаасны тэтгэвэрт хамрагддаг 12672 хүний бүгд 7,8 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний улмаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэрт байдаг 6802 хүний бүгд 4,4 тэрбум төгрөгийг хугацаанд нь бүрэн олгожээ.

Сангийн яам, НХХЯ, Үндэсний статистикийн газарт тэтгэвэр, тэтгэмж олголтын албан мэдээллийг сар бүр хүргүүлж байгаа бөгөөд аймаг, дүүргийн НДХ-үүдэд хийсэн аудитын тайлангаас үзэхэд тэтгэвэр, тэтгэмж цаг хугацаа алдсан, дутуу дулимаг олгогдсон зөрчил, гомдол санал гараагүй байна.

Улсын төсвөөс тэтгэврийн санд олгохоор төсөвлөсөн 44224,1 сая төгрөгийг Төв төрийн сангаас сар бүр хуваарийн дагуу олгож ирсэн нь тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь бүрэн олгох гол нөхцөл болжээ.

НДҮЗ-ийн үйл ажиллагаа**Ирц бүрдээгүй байхад хуралдаж, шийдвэр гаргажээ.**

УИХ-ын НББХ-ны 2000 оны 3 дугаар тогтоолоор НДҮЗ-ийн дүрмийг баталсан бөгөөд уг зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдаж нийгмийн даатгалын асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргаж байх ёстой.

Гэтэл НДҮЗ нийгмийн даатгалын асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж иржээ.

Дүрмийн дагуу НДҮЗ-ийн хуралдаан нь 8 ба түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдвал хүчинтэйд тооцох ёстой байтал 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд 7 гишүүн оролцож, 24-33 хүртэл дугаартай 10 тогтоолыг батлан гаргажээ.

Холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, өөртөө хөрөнгө оруулалтын төсөв баталжээ

НДҮЗ-ийн дүрэмд зааснаар тус зөвлөл нь бие даасан төсөвтэй байх бөгөөд төсвийг УИХ-ын НББХ-гоор батлуулж байх ёстой.

Гэтэл НДҮЗ 2005 оны 7 дугаар сард гаргасан 20 дугаар тогтоолоор НД-ын байгууллагуудын 2005 оны хөрөнгө оруулалтын төсөвт тодотгол хийхдээ өөртөө 10,0 сая төгрөгийг автомашин авахад зориулан баталж, олгуулжээ.

НДҮЗ-д автомашин худалдан авах хэрэгцээ, шаардлага байхгүй тул уг хөрөнгийг буцаан төлүүлж, НДС-нд төвлөрүүлэх нь зүйтэй байна.

НДҮЗ өөрийн чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлж байна

НДҮЗ-ийн гол үйл ажиллагаа нь НД-ын хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, боловсронгуй болгоход чиглэгдэх ёстой.

“Улсын төсвийн удирдлагын шинэчлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2002 оны 119 дүгээр тогтоолд улс, орон нутгийн төсвийн бүтцээс НДС-гийн орлого, зарлагыг 2003 оноос эхлэн тусгаарлаж, уг санг

бие даасан байдалд шилжүүлэх дэс дараатай алхам хийх талаар тусгагджээ.

Гэвч 2002 онд батлагдсан ТБУСТХ –ийн хүрээнд Засгийн газрын 2002 оны “Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 272 дугаар тогтоолоор НДС-г төрийн сангийн нэгдсэн дансанд 2003 оны 1 дүгээр сарын 1-нээс байршуулсан нь шинэчлэлийн талаарх үндсэн чиглэлийн үзэл баримтлалд нийцээгүй төдийгүй Засгийн гарын 2002 оны 119 дүгээр тогтоолыг үгүйсгэжээ.

Дүгнэлт

НДҮЗ Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд НДС-гийн бие даасан байдлыг хангах, чөлөөт үлдэгдлийг арвижуулах талаар дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар дорвитой арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна.

НДҮЗ нь НДТХ болон өөрийн дүрмээр хүлээсэн үүргийн дагуу НДБ-ын зардлын төсвийг батлах төдийгүй, түүний гүйцэтгэлд хяналт тавьж байх ёстой.

НДҮЗ 2005 оны 20, 22, 23 дугаар тогтоолоор НДБ-уудын 2005 оны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны төсвийг бүгд 1235,3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, тодотгон батлахдаа шаардагдах нэмэлт зардлыг НДС-гийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулснаас санд төлөгдсөн хүү болон хугацаандаа төлөгдөөгүй НДШ-ийн ногдуулсан алдангаас бий болох орлогоос санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Гэтэл дээрх орлого НДС-д бодитойгоор бий болоогүй байхад УНДЕГ НДС-гийн хөрөнгөөс 1235,3 сая төгрөгийг шууд татан авчээ.

НДБ-уудын 2005 оны санд төлөгдсөн хүүгийн болон алдангийн орлого бүгд 855,3 сая төгрөг болсноос үзэхэд УНДЕГ эрх мэдлээ хэтрүүлэн, холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, дур мэдэн НДС-гаас 380,0 сая төгрөгийг захиран зарцуулсан нь НДҮЗ орлого бий болоогүй байхад захиран зарцуулах эрхийг урьдчилж олгосон, хоёрдугаарт НД-ын байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргээ

НДҮЗ-ийн үйл ажиллагаа

үргэлжлэл

хэрэгжүүлээгүй, гаргасан эрсдэлтэй шийдвэрийнхээ хэрэгжилтийг эргэж хянаагүйтэй холбоотой.

Хууль тогтоомжийн дагуу НДҮЗ НДС-гийн орлого, зарлагад хийх шалгалтад хяналтын болон аудитын байгууллагыг оролцуулах эрхтэй ч өөрийн санаачлагаар хөндлөнгийн байгууллагын шалгалт, дүгнэлт огт хийлгэж байгаагүй байна.

Дүгнэлт

НДС-гийн болон НД-ын байгууллагын зардлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргээ НДҮЗ хангалтгүй хэрэгжүүлжээ

НДҮЗ нь хууль болон дүрмээр тодорхойлогдсон эрх, үүрэгтэй, ажлаа УИХ-д тайлагнадаг, бие даасан төсөвтэй байгаагаас үзэхэд НД-ын байгууллагын үйл ажиллагааг удирдах, хянах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

НДҮЗ-ийн одоогийн дарга, гишүүд нь УИХ-ын 2004 оны 32 дугаар тогтоолоор шинэчлэгдэж, 2006 оны 1 дүгээр сард бүрэн эрхийн хугацаа дуусвар болсон боловч өнөөг хүртэл бүрэлдэхүүнийг шинээр томилоогүй байна.

НДҮЗ-ийн бүрэлдэхүүнд УНДЕГ-ын дарга, мөн УМХГ-ын хэлтсийн дарга албан тушаалаараа орж байгаа нь шийдвэр гаргах болон гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжсэн гүйцэтгэлийг хянах зэрэг чиг үүрэг давхардсан байх тул бүтэц, төлөөллийн хувьд оновчтой бус байна.

Тус зөвлөл орон тооны бус гишүүнчлэлтэй бөгөөд нарийн бичгийн дарга нь орон тооны ажилтан юм.

НДҮЗ-ийн нарийн бичгийн дарга нь УНДЕГ-ын хэлтсийн даргын албан тушаалын цалин хангамж эдэлдэг бөгөөд УНДЕГ-г байрлаж байна.

НДҮЗ-ийн 2005 оны жилийн ажлын тайланг уншиж үзэхэд УНДЕГ-ын 2005 оны жилийн ажлын тайлангийн агуулгыг давтсан, өөрөөр

хэлбэл НДҮЗ-ийн хийсэн ажил гэж огт харагдахгүй байгаад дүгнэлт хийхээр байна.

Дүгнэлт

НДҮЗ өнөөгийн хууль, эрх зүйн орчны хүрээнд НД-ын байгууллагын үйл ажиллагааг удирдах, хянах бүрэн боломжтой боловч чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлжээ.

НДҮЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын хариуцлагыг дээшлүүлж, ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг тодорхой болгож, ажлын үр дүнд үндэслэн цалин, урамшуулал олгож байх нь зүйтэй.

НХХ-ийн сайдаас ирүүлсэн санал



**МОНГОЛ УЛСЫН
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

210646 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5,
утас: 26-15-53, факс: 32-86-34, E-mail: Mswf@mongolnet.mn

2006.03.22 № 1/442
танай 2006.03.14-ны № 1/95 -Т
Санал хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л. ЖАВЗМАА ТАНАА

Нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, Нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Энэ удаагийн аудитын шалгалтаар Нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, байгууллагуудын хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны санхүүжилт, байгууллагын удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, өр авлагын барагдуулалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, нөлөө зэрэг өргөн хүрээнд шалгалт хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгсөн байна.

Урьдчилсан тайлангаас Нийгмийн даатгалын сангийн 2005 оны орлогын төлөвлөгөөг 5%-иар давуулан биелүүлсэн, тэтгэвэр, тэтгэмж хугацаандаа олгогдсон, санхүүгийн тайлан мэдээлэл хуулийн хугацаандаа гарч байсан зэргээс нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байжээ гэж дүгнэж болохоор байна.

Гэвч Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар Нийгмийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийг холбогдох шийдвэргүй, үр ашиггүй, зориулалтын бусаар, зарцуулсан, үрэн таран хийсэн тохиодол нилээд их гарсан болохыг тайланд дурдсан байна. Түүнчлэн Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний харьяа салбарууд орон тоо, бүтцийг шинэчлэхдээ холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй, боловсон хүчнийг сонгон шалгаруулж ажилд авдаггүй, дотоод хяналтын хамрах хүрээ өргөжөөгүй, мэдээллийн технологийн нууцлал, аюулгүй байдлал хангалтгүй зэрэг дутагдал зөрчлүүд гарсан нь ойрын хугацаанд засч сайжруулах, дүгнэлт хийх, боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Аудитын шалгалтын дүнгээс үзэхэд Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (НДҮЗ) нийгмийн даатгалын талаар санал зөвлөмж, дүгнэлт гаргах үүргээ хангалтгүй биелүүлсэн, Нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангах, чөлөөт үлдэгдлийг арвижуулах талаар дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар дорвитой арга хэмжээ аваагүй, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны зүгээс хөрөнгө оруулалтын тендерт тавих хяналтыг сулруулсан, холбогдох байгууллагын санал, тендергүйгээр гэрээ байгуулж эд хөрөнгө худалдан авсан зэрэг дутагдлууд байсанд дүгнэлт тэдгээрийг арилгах шуурхай арга хэмжээ авах болно.

Шалгалтаар гарсан дүгнэлт, үнэлгээг үндэслэн дараах асуудлуудыг холбогдох байгууллагуудын ажлын зөвлөмжид тодорхой тусгаж өгөхийг санал болгож байна. Үүнд:

00 335

НХХ-ийн сайдаас ирүүлсэн санал

үргэлжлэл

1. Нийгмийн даатгалын сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Монгол банкинд хадгаламж хэлбэрээр байршуулан хүү тооцон авч санг нэмэгдүүлэх асуудлыг боловсруулан шийдвэрлэхийг Сангийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Монгол банкны удирдлагад;

2. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлага нь албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрсэн тул хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд сахилгын шийтгэл оногдуулах эсэх талаар саналаа тодорхой болгож эрх бүхий байгуулага, албан тушаалтанд;

3. Ажил олгогчдыг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн үүргээс чөлөөлөх хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд;

4. Үндсэн хуулийн 19.1 дэх заалт, бусад орны туршлагыг үндэслэн Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх боломжийг судалж, шийдвэрлэхийг УИХ-ын Төсвийн бодлогын байнгын хороо, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яаманд;

5. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд;

Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, үйл ажиллагааг сайжруулах аргачлал, зөвлөмжүүдийн холбогдох байгуулагуудад өгсөн гэж үзэж байна.



САИД

Л. ОДОНЧИМЭД

УНДЕГ-аас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32-80-30, Факс: 32-07-16,
E-mail: SSI.GOMON@magicnet.mn

2006.08.21 № 350

танай _____-ны № _____-г

┌ УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ┐
ЕРӨНХИЙ АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

Таны ирүүлсэн Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын урьдчилсан дүгнэлтийг хүлээн авч, холбогдох тайлбарыг хүргүүлэв.

 ДАРГА  С.ЭРДЭНЭ

My doc.Zakhirгаа A-5.doc

10 0510

Тайлбар:

УНДЕГ-аас аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн санал, тайлбар нь бүгд 75 хуудас материал болсон тул тайланд оруулах боломжгүй байна.

НХХ-ийн сайдын саналд өгсөн тайлбар**Санал 1-д өгөх тайлбар**

Ирүүлсэн саналыг үндэслэн НДС-гийн зарцуулагдаагүй үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Монгол банкинд хадгаламж хэлбэрээр байршуулан, хүү тооцон авч санг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэхийг НХХ-ийн сайдад зөвлөмж болгов.

Санал 2-д өгөх тайлбар

Ирүүлсэн саналыг үндэслэн УНДЕГ-ын удирдлага ТБОНӨХХАБАҮГСЖТухай хуулийг удаа дараа зөрчсөн нь аудитаар илэрсэн тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулахыг НХХ-ийн сайдад зөвлөмж болгов.

Санал 3-д өгөх тайлбар

Ажил олгогчдыг НДШ-ийн төлбөрийн үүргээс чөлөөлөх талаар тусгайлан хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагыг аудитаар зөвлөмж болгох шаардлагагүй гэж үзэж байна. Харин НДШ-ийн хугацаа хэтэрсэн авлага аль болох үүсгэхгүй байх, үүссэн тохиолдолд барагдуулах талаар эрчимтэй ажиллахыг холбогдох талуудад зөвлөмж болгосон болно.

Санал 4-д өгөх тайлбар

Ирүүлсэн саналын дагуу холбогдох зөвлөмжийг УИХ-ын Төсвийн Байнгын хороонд зөвлөмж болгов.

Санал 5-д өгөх тайлбар

НД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шаардлагатай бол өөрчлөх, сайжруулах асуудлыг Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар НДҮЗ-д зөвлөмж болгосон болно.

УНДЕГ-ын саналд өгсөн тайлбар**2. УНДЕГ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар:**

УНДЕГ-аас ирүүлсэн санал нь нэгдсэн дугааргүй байгаа тул хуудасны дугаарын дагуу саналд тайлбар бэлтгэв. Аудитын явцад УНДЕГ-ын холбогдох албан тушаалтнуудаас гаргаж өгсөн мэдээлэл удирдлагын тайлбар, гаргасан мэдээлэлтэй харилцан зөрүүтэй байснаас аудитын тайлангийн төсөлд тусгагдсан зарим дүгнэлт, мэдээллийг ирүүлсэн тайлбарын дагуу залруулсан болно.

УНДЕГ-аас ирүүлсэн санал (Хуудас 1-6)-д өгөх тайлбар:

- Аудитын тайланд тусгагдсан НДС-гийн орлогын дүн нь Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын сан болон эрүүл мэндийн даатгалын санд олгосон санхүүжүүлт 49,0 тэрбум төгрөгийг оруулж тооцоолсон дүн болно.
- Татан буугдсан арилжааны банкуудтай холбоотой 10,9 тэрбум төгрөгийн авлага нь өөрийн хяналтад байгаа хөрөнгө биш бөгөөд НББОУС-ын дагуу болзошгүй хөрөнгө тул НББОУС №37-г баримтлан тус авлагыг санхүүгийн тайланд хөрөнгө байдлаар толилуулахгүй байх нь зүйтэй. Ингэснээр НДС-гийн хуримтлагдсан үр дүн буюу зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгө 2005 оны жилийн эцсийн байдлаар 125,0 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд энэ дүнг 2005 оны НДС-гийн тэтгэвэр, тэтгэмжийн нийт зарцуулалт 155,6 тэрбум төгрөгт харьцуулбал 9,64 буюу ойролцоогоор 10 сарын нөөц бүрдсэн байна.
- Аудитын тайлангийн төсөлд бичигдсэн дүгнэлтийг дутуу ойлгосон байна. УНДЕГ НДШ-ийн ногдуулалтын мэдээг ерөнхийд нь гаргаж байгаа боловч хэдийг нь цаг хугацаанд нь төвлөрүүлж байгаа талаар нэгдсэн мэдээлэл гаргаж өгч чадаагүй тул аудитаар НДС-г цаг хугацаанд нь бүрэн бүрдүүлж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах боломж олдоогүй. Тиймээс НДШ-ийн ногдуулалт, түүнийг цаг хугацаанд нь хэрхэн барагдуулж байхыг тусгайлан тодорхойлж, биелэлтийг хангуулж байхыг зөвлөмж болгосон.
- Аудитын тайлан дахин анхааралтай уншиж, даатгуулагчдын өмчийн хэлбэрээр ялгаварласан утгатай дүгнэлт гаргаагүй болохыг ойлгож болно. Харин НДС-гийн орлого бүрдүүлэлтэд Улсын төсвийн үүрэг оролцоог тодруулах үүднээс НДШ-ийн орлогын 25,06% -ийг Төрөөс хариуцах иргэдийн ЭМД-ын хураамж, тэтгэвэр, төсөвт байгууллагаас төлөгдсөн төлбөр эзэлж байгаа талаар харьцуулалт хийсэн.
- “Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх журмын”-ын 2.8-т “Нийгмийн даатгалын байгууллага нь СЭЗ-ийн сайдын тусгай зөвшөөрөлгүйгээр төрийн сангаас гадуур банк болон санхүүгийн байгууллагад данс нээхийг хориглоно” гэж заасныг зөрчиж, УНДЕГ холбогдох зөвшөөрөлгүйгээр бүгд 5,2 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад байршуулсан нь аудитаар нотлогдсон болно.
- “Нийгмийн даатгалын сан, нийгмийн даатгалын байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэх журам” нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1.3, 11 дүгээр зүйлийн 2, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийг зөрчөөгүй, харин шаардлагатай зарим харилцааг нарийвчлан зохицуулсан хууль эрхийн акт гэж үзэж байна.

УНДЕГ-аас ирүүлсэн санал (Хуудас 16-39)-д өгөх тайлбар:

- “Залаат” амралтыг худалдан борлуулсан үйл ажиллагааг хүчингүй болгох шаардлагатай гэсэн дүгнэлтээ эргэн харах саналыг хүлээж авсан болно.
- Ирүүлсэн тайлбар болон холбогдох тооцооллыг давтан шалгасны үндсэн дээр Сангийн сайд болон НХХ-ийн сайдаас ирүүлсэн саналд үндэслээгүй гэдэг дүгнэлтийг залруулсан.
- Ирүүлсэн тайлбар болон холбогдох тооцооллыг давтан шалгасны үндсэн дээр УНДЕГ зардлын төсвийг боловсруулахдаа арвилан хэмнэлтгүй хандсан талаарх дүгнэлтийг залруулсан болно.
- Ирүүлсэн тайлбар, холбогдох мэдээллийг үндэслэн НД-ын маягтны нөөцтэй холбоотой мэдээлэл, дүгнэлт, холбогдох албан шаардлага, зөвлөмжийг залруулсан.

УНДЕГ-ын саналд өгсөн тайлбар

үргэлжлэл

- Орлогч даргын орон тоог биш, харин албан тушаалыг шинээр бий болгосон байдлаар залруулав.
- УНДЕГ-ын дарга, орлого даргаас бусад гүйцэтгэх албан тушаалтнууд төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд хамаарч ирсэн нь Төрийн албаны тухай хуулийн 7.1.7 заалттай зөрчилдөж байгааг залруулан дүгнэсэн.
- УНДЕГ НДС-гийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр ажилтнуудын нийгмийн асуудал, орон сууцны хөнгөлөлтийг тодорхой шалгуур, батлагдсан журамгүй олгож байна. Иймд холбогдох журам боловсруулж, мөрдөх шаардлага өгсөн.

УНДЕГ-аас ирүүлсэн санал (Хуудас 45-46)-д өгөх тайлбар:

- 2005 оны эхний 3 дугаар улиралд /2005 оны 10 дугаар сарын 21-н хүртэл/ УНДЕГ-ын даргын 2005 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 тоот тушаалаар бүтцэд хамааралтай захиргааны хэлтэст 3 алба шинээр бий батлан ажиллуулж ирсэн нь Нийгмийн даатгалын тухай хууль болон НДҮЗ-ийн 2000 оны 6 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.
- НХХ-ийн сайдын 112 дугаар тушаал нь Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1 дэх заалтыг, тухайлбал, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Монгол улсын сайд батална гэсэн нөхцөлийг удирдлага болгожээ. Энэ нь НДТХ-ийн 27 дугаар зүйлийн 3.6 дахь заалт (Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг НДҮЗ батална)-тай зөрчилдөж байгаа юм. Иргэний хуулийн 3-ийн 3-т заасан "...хэрэв хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заасан байдаг тул Нийгмийн даатгалын тухай хуулийн заалтыг мөрдлөг болгох нь зүйтэй байсан гэж үзэж байна.

УНДЕГ-аас ирүүлсэн санал (Хуудас 48-53)-д өгөх тайлбар:

- УНДЕГ-ын даргын 2001 оны 8 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хяналт, үнэлгээний хэлтсийн ажлын чиг үүрэгт ямар нэгэн өөрчлөлт хийгдээгүй. Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 15.в-д заасан үүрэг нь Хяналт, үнэлгээний хэлтсийн үйл ажиллагааны ажлын зөвхөн нэг хэсэг юм.
- Хяналт, үнэлгээний хэлтэс нь НДС-гийн орлого, зарлагын төлөвлөлт, түүний үндэслэлд шинжилгээ хийж дүгнэлт гаргах, улирал жилийн тайлан тэнцлийн үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийх, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлын хэтрэлт хэмнэлтийн шалтгаанд шинжилгээ хийж, жилийн зардлын төсөв зохиох, төлөвлөхөд тодорхой санал боловсруулах чиг үүргийн дагуу тодорхой ажил хийгээгүй байна.
- Мэдээлэл, технологийн нууцлал, аюулгүй байдал, дүрэм журам хангалтгүй байгаа талаар аудитын явцад холбогдох албан тушаалтанд өгч байсан санал, зөвлөмжийн мөрөөр тодорхой ажил, хийж, үр дүнд хүрсэн байх тул аудитын тайлангаас холбогдох дүгнэлтийг хассан болно.

УНДЕГ-аас ирүүлсэн санал (Хуудас 58-63)-д өгөх тайлбар:

- НДҮЗ-ийн дүрмийн "Нийтлэг үндэслэл"-ийн 1.4-т хурал 8 ба түүнээс дээш гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдвал хүчинтэйд тооцох, 1.5-т хуралдааны шийдвэр нь гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар шийдвэрлэгдэх заажээ. Гэвч хуралдааны бүрэлдэхүүний ирц, гаргасан шийдвэр нь дүрмийн заалтын хүчин төгөлдөр байх үндэслэлийг зөрчсөн байна.

Албан шаардлага

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасныг үндэслэн холбогдох албан тушаалтанд дараахь албан шаардлага өгөв.

УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА С.ЭРДЭНЭД

- Арилжааны банкуудад байршуулсан НДС-гийн мөнгөн хөрөнгийг татан авч, Төрийн санд төвлөрүүлэх;
- Байгуулсан гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн, холбогдох анхан шатны баримтын бүрдэлгүй байхад “Натур фурнитур”ХХК-д олгосон 28,2 сая төгрөгийн баримтыг бүрдүүлж, ҮАГ-ын газарт эргэж шалгуулах;
- НДС-ийн авлагыг барагдуулахаар “Марагал” ХХК-тай хамтран ажиллах гэрээг цуцалж, холбогдох авлагыг барагдуулах талаар хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ биелүүлж ажиллах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж байх;
- НДС-ын байгууллагын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцны хөнгөлөлт олгоход баримтлах дотоод журмыг боловсруулж, мөрдөж ажиллах

Гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох байгууллага, албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хорооны дарга Ч.Улаанд

- I. Үндсэн хуулийн 19.1 дэх заалт, бусад орны туршлагыг үндэслэн НД-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

Улсын Их Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын Хорооны дарга Т.Гандид

- II. Үндсэн хуулийн 19.1 дэх заалт, бусад орны туршлагыг үндэслэн НД-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- III. Бүрэн эрхийн хугацаа нь дуусвар болсон НДҮЗ-ийн бүрэлдэхүүнийг томилж, өнөөгийн төлөөллийн бүтцийг эргэж харах.

Сангийн Сайд Н.Баяртсайханд

- I. 1995 оноос өмнө тэтгэвэрт гарагчдад олгосон тэтгэврийн хөрөнгийг Улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж ирээгүйгээс бий болсон өр төлбөрийг тооцож, НДС-д нөхөн төвлөрүүлэх асуудлыг судалж, шат дараатай шийдвэрлэх;
- II. УНДЕГ болон Төрийн сангийн газрын хооронд байгуулсан 2005/01 дугаартай гэрээний нөхцлийн дагуу НДС-д төлөгдөөгүй хүүг нөхөн тооцож, олгох.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Сайд Л.Одончимэдэд

- I. Үндсэн хуулийн 19.1 дэх заалт, бусад орны туршлагыг үндэслэн НД-ын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- II. МӨСЭХМТ-д худалдаж авсан Хандгайт дахь “Сантаун” амралтын газар нь мэргэжлийн өвчний сувиллын үйлчилгээ эрхлэх шаардлага хангах эсэхийг УМХГ-аар дүгнэлт гаргуулж, шаардлага хангаагүй тохиолдолд худалдан авалтыг буцаах;
- III. НДС-гийн зарцуулагдаагүй үлдэгдэл мөнгөн хөрөнгийг Монгол банкинд хадгаламж хэлбэрээр байршуулан, хүү тооцон авч санг нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх;
- IV. Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн НДҮЗ-ийн дарга С.Чинзориг, УНДЕГ-ын дарга С.Эрдэнэ нарт сахилгын шийтгэл ногдуулж, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.13-т заасан хугацаанд хариу мэдэгдэх.

Зөвлөмж

үргэлжлэл

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ЧИНЗОРИГТ

- I. Шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар НДС-гийн хөрөнгийг эрсдэлд өртүүлэхгүйгээр, өсгөн арвижуулах арга замыг судалж, хэрэгжүүлэх;
- II. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн дагуу НДС-ийн орлого, зарлага, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- III. НДС-гийн орлогыг хянаж, батлахдаа шимтгэл ногдуулалт болон түүнийг хэзээ хэрхэн барагдуулахыг тусгайлан тодорхойлж, биелэлтийг хангуулж байх;
- IV. Төрөөс ЭМД-ын төлбөрийг хариуцах иргэдийн даатгалын хураамжийг 300 төгрөгийн хэмжээнд байлгах боломжийг судалж, 500 төгрөг болгож нэмэгдүүлсэн шийдвэрийн үндэслэлийг эргэн харах;
- V. 2005 онд ажил олгогчдын урамшуулал болон банкны үйлчилгээний төлбөрт зориулж олгосон төсвөөс зарцуулагдаагүй үлдэгдэл 89,1 сая төгрөгийг 2006 онд тэдгээр зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт тооцож, батлагдсан төлөвлөгөөг залруулах;
- VI. НДҮЗ-ийн 2005 оны 8 дугаар тогтоолоор орон сууцны барилгын талбайн зөрүүд НДС-гаас төлсөн 49,5 сая төгрөгийн 40%-ийг орон сууцанд орсон ажиллагсдаар нөхөн төлүүлж, НДС-д төвлөрүүлэх;
- VII. Хууль, тогтоомж зөрчин, НД-ын хөрөнгө оруулалтын зардлын дүнд оруулан автомашин худалдан авахад зориулан өөртөө баталж авсан 10,0 сая төгрөгийг буцаан төлж, НДС-д төвлөрүүлэх;
- VIII. НХХ-ийн сайдын 2005 оны 112 дугаар тушаалыг хүчингүй болгуулж, НДТХ-ийн 27.6-р заалтыг биелүүлж ажиллах.

УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА С.ЭРДЭНЭД

- I. “Молор трейд” ХХК-ний бариулж байгаа орон сууцны үнэнд нийгмийн даатгалын байгууллагаас олгосон хөрөнгийг барилга ашиглалтад орж, НДБ-ын ажилтнуудад орон сууц эзэмших эрх шилжтэл НББ-д авлагаар бүртгэж, барилгын явц, чанар байдалд хяналт тавьж, байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу хариуцлага тооцож ажиллах;
- II. НДШ-ийн төлбөрт хөрөнгө үнэлэн авч байгааг таслан зогсоож, асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлж байх, шимтгэлийн төлбөрт хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө авах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд тэдгээрийг нийтийн дуудлага худалдаагаар худалдан борлуулж, борлуулалтаас НДС-д төлөгдсөн мөнгөн дүнг үндэслэн НДШ-ийн төлбөрийг барагдуулсан тооцоог хийж байх;
- III. Дампуурсан арилжааны банкуудтай холбоотой 10,9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх;
- IV. НДШ-ийн болон банкны өрөнд хурааж авсан бараа, объектэд дахин үнэлгээ хийлгэж, холбогдох журмын дагуу бүртгэл, тайланд тусгах;

Зөвлөмж

үргэлжлэл


- V. НДШ-ийн авлага үүсгэхгүй байх, үүссэн авлагыг бүрэн барагдуулах талаар хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ биелүүлж ажиллах;
- VI. УНДЕГ-ын дотоод хяналтын албаны чиг үүрэгт хураагдсан бараанд хяналт тавих талаар тусгаж, дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулах;
- VII. НДШ-ийн төлбөрийн тооцоонд хураан аваад байгаа бараа, объектыг нийтийн дуудлага худалдаагаар худалдан борлуулж байх;
- VIII. НДҮЗ-ийн 2000 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан УНДЕГ-ын бүтцийг мөрдөх, шаардлагатай гэж үзвэл бүтцийг НДҮЗ-өөр дахин батлуулж, мөрдөж ажиллах;
- IX. НД-ын байгууллагын ажилтны хариуцан гүйцэтгэх ажлын нормативыг шаардлагатай гэж үзвэл шинэчлэн тогтоож, тогтоосон нормативыг хангахуйц орон тоо, бүтцийг мөрдөж ажиллах;
- X. Холбогдох хууль тогтоомжийн дагуу НДБ-ын гүйцэтгэх ажилтнуудыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамруулахыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;
- XI. НД-ын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагч, ажилтан, ажил олгогч нарт хяналт шалгалтын орлогоос шагнал, дэмжлэг туслалцаа үзүүлэх тухай журам”-ыг бүрэн мөрдөж ажиллах;
- XII. УНДЕГ-ын Хяналт, үнэлгээний хэлтсийн чиг үүргийг өргөжүүлж, хамрах хүрээг нэмэгдүүлэн, жилийн ажлын төлөвлөгөөнд чиг үүрэг тус бүрээр хийх ажлыг баталж, хэрэгжилтийг хангуулж байх.

ҮАГ-ЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.МЭНДБАЯР

НД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт

2005 он



**НД-ын байгууллагын үйл ажиллагаа,
хөрөнгө оруулалтын зардлын судалгаа**

(сая төгрөгөөр)

№	Зардлын нэр төрөл	2004 оны гүйцэтгэл	2005 оны			2004 онтой харьцуулбал
			төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	
1	Үйл ажиллагааны зардал	3811.3	4708.5	4575	-133.5	763.7
	Цалин, НДШ	1488.9	1914.1	1925.7	11.6	436.8
	Бүгд орон тоо	1021	1115	1177	62	156
	Үүнээс: удирдах ажилтан	51	66	72	6	21
	бараа, үйлчилгээний зардал	1170.2	1615	1552.3	-62.7	382.1
	банкны үйлчилгээний зардал		314.7	257.9	-56.8	257.9
	ажил олгогчдын урамшуулал		119.6	87.3	-32.3	87.3
	ажлын хувцас		104.5	113.7	9.2	64.6
	ажлын хувцасны гүйцэтгэлийн дүнгээс хөрөнгөд бүртгэгдсэн дүнгээр хийгдэх залруулга			-49.1	-49.1	
	орон сууцны дэмжлэг	1152.2	640.6	687.2	46.6	-465
2	Хөрөнгө оруулалтын зардал	1235.7	2057.5	2055.5	-2	819.8
	конторын барилга	728.8	870.7	862.9	-7.8	134.1
	их засвар	70.7	406.6	404	-2.6	333.3
	автомашин	166.1	92	92	0	-74.1
	бусад	370.2	688.2	696.6	8.4	326.4
3	Нийт зардлын дүн	5046.9	6766	6630.5	-135.5	1583.6
4	Нийт орлого	4437.1	6766.1	7167.2	401.1	2730.1
	НДС-гийн санхүүжилт	4153.1	6507.9	6507.9	0	2354.8
	Үйл ажиллагааны орлого	272	258.2	336.3	78.1	64.3
	Бусад	12		4.7	4.7	-7.3

**УНДЕГ, Нийслэлийн НД-ын газар, аймаг, дүүргийн НДХ-үүдэд
хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

№	Хариуцагч байгууллага	Төлбөр зөрчлийн агуулга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Төлбөр зөрчлийн дүн
1	УНДЕГ	Тендер шалгаруулаагүй худалдан авалт		1 223 200,0	1 223 200,0
2	УНДЕГ	Сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан		46 500,0	46 500,0
3	НДҮЗ	Өөртөө төсөв баталсан		10 000,0	10 000,0
4	Архангай НДХ	Үнэт цаасны төлбөр тооцоотой холбоотой	105,1		105,1
5	Архангай НДХ	Баримтын бүрдэлгүй зарцуулсан	5 113,0		5 113,0
6	Архангай НДХ	НДШ-ийн өрөнд авсан барааны үнэ төлүүлэх	6 847,5		6 847,5
7	Дархан Уул НДХ	Зориулалт бусаар байршуулсан	215 994,0		215 994,0
8	Дархан Уул НДХ	Арилжааны банкинд байршуулсны хүү		4 560,0	4 560,0
9	Дорноговь НДХ	Авлага шийдвэрлүүлэх тухай		5 000,0	5 000,0
10	Дорноговь НДХ	Төлөгдөөгүй шимтгэлийг санд төлүүлэх	290,0		290,0
11	Дорноговь НДХ	Илүү олгосон санхүүжилт	4 370,8		4 370,8
12	Увс НДХ	Шимтгэл төлүүлэх	182,4		182,4
13	Сэлэнгэ НДХ	Шимтгэл төлүүлэх	285,7		285,7
14	Сэлэнгэ НДХ	Дутуу олгосон тэтгэмж		1 551,9	1 551,9
15	Хөвсгөл НДХ	НДШ төлүүлэх	404,8		404,8
16	Баян-Өлгий НДХ	ХАОАТ төлүүлэх	168,4		168,4
17	Баян-Өлгий НДХ	Баримтын бүрдэлгүй зарцуулсан		839,9	839,9
18	Булган НДХ	ХАОАТ төлүүлэх	168,3		168,3
19	Булган НДХ	Хураагдсан барааны үнэ төлүүлэх		10 000,0	10 000,0
20	Орхон НДХ	Төлбөр барагдуулах	567,9		567,9
21	Орхон НДХ	Бүртгэлд тусгах		5 479,6	5 479,6
22	Төв НДХ	Зориулалт бусаар зарцуулсан	3 247,4		3 247,4
23	Төв НДХ	Бүртгэлд тусгах		3 016,0	3 016,0
24	Говьсүмбэр НДХ	Илүү олгосон тэтгэмжийг төлүүлэх	369,6		369,6
25	Завхан НДХ	Зориулалт бусаар зарцуулсан	444,7		444,7
26	Ховд НДХ	Илүү олгосон санхүүжилт	1 039,2		1 039,2
27	Ховд НДХ	ХАОАТ төлүүлэх	96,5		96,5
28	СХД-ийн НДХ	Зориулалт бусаар зарцуулсан		12 700,0	12 700,0
29	СХД-ийн НДХ	НДШ-ийг алдангийн хамт төлүүлэх	7 900,0		7 900,0
30	БГД-ийн НДХ	Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах		39 985,0	39 985,0
31	БГД-ийн НДХ	Бүртгэлд тусгах		10 900,0	10 900,0
32	НД-ийн НДХ	Алданги төлүүлэх	2 200,0		2 200,0
	Бүгд дүн		249 795,3	1 373 732,4	1 623 527,7

УНДЕГ-ын бүтэц, орон тоо
2005 он

/НДҮЗ-ийн 2000 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан		УНДЕГ-ын даргын 2005 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан		/УНДЕГ-ын даргын 2005 оны 285 дугаар тушаалаар батлагдсан	
бүтэц	орон тоо	бүтэц	орон тоо	бүтэц	орон тоо
Стратеги төлөвлөлтийн хэлтэс	4	Стратеги төлөвлөлтийн хэлтэс	5	Бодлого зохицуулалт, төлөвлөлтийн хэлтэс	6
Орлого, санхүүжилтийн хэлтэс	5	Орлого, санхүүжилтийн хэлтэс	6	Санхүү, бүртгэлийн хэлтэс	6
Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэс	4	Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэс	7	Хяналт, үнэлгээний хэлтэс	13
Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	4	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	6	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	6
Захиргааны хэлтэс	10	Захиргааны хэлтэс	21	Захиргааны хэлтэс	26
		• Захиргаа	7	• Захиргаа	13
		• Сургалт, сурталчилгааны алба	4	• Сургалт, маркетингийн алба	3
		• Аж ахуйн алба	8	• Өмчийн харилцааны алба	8
		• Байр ашиглалтын захиргаа	2	• Байр ашиглалтын алба	2
Газрын дарга	1	Газрын дарга	1	Газрын дарга	1
Орлогч дарга	1	Орлогч дарга	2	Орлогч дарга	2
(НДҮЗ-ийн 2005 оны 4 дүгээр тогтоолоор орлогч даргын орон тоог нэмсэн)		• НДС, бодлого хариуцсан орлогч дарга	1	• НДС, бодлого хариуцсан орлогч дарга	1
		• НД-ын аж, ахуйн үйл ажиллагаа хариуцсан орлогч дарга	1	• НД-ын аж, ахуйн үйл ажиллагаа хариуцсан орлогч дарга	1
Бүгд орон тоо	29		48		60